





UNITED NATIONS
INDUSTRIAL DEVELOPMENT ORGANIZATION

АЖЛЫН БАЙРАНД АНХНЫ ТУСЛАМЖ ҮЗҮҮЛЭХ НЬ

ХОЛИМОГ СУРГАЛТЫН БАГШИЙН ГАРЫН АВЛАГА



This project is funded by
the European Union



Food and Agriculture
Organization of the
United Nations



UNITED NATIONS
INDUSTRIAL DEVELOPMENT ORGANIZATION



Энэхүү гарын авлагыг Европын Холбооны санхүүжилтээр НҮБ-ын Аж үйлдвэр хөгжлийн байгууллагаас Монгол Улсын Засгийн газар, НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагатай хамтран хэрэгжүүлж буй "Монгол Улсад Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих (SECiM C2)" төслийн хүрээнд Монголын Улаан Загалмайн Нийгэмлэгийн сургагч багш, хүний их эмч Б.Гантулга, төслийн цахим сургалтын мэргэжилтэн Я.Цэцэг-Өлзий нар боловсруулав.

ӨМНӨХ ҮГ

Ажлын байранд гарч болох аюул, эрсдлүүдийг таниулах, аливаа осол гэмтэл, гэнэтийн өвчлөлүүдийн үед хамгийн ойр байгаа хүн осолдогчид анхны тусламжийг аюулгүй, зөв үзүүлэх мэдлэг, чадвар, дадал, хандлагыг бий болгох нь нэн чухал билээ.

НҮБ-ын Аж үйлдвэр хөгжлийн байгууллагаас боловсруулсан, зохистой хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээрх хэд хэдэн цахим сургалтыг Европын Холбооны санхүүжилттэй “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих” төслийн хүрээнд монгол хэлнээ нутагшуулан хүргэж байгаагийн нэг нь “Ажлын байранд анхны тусламж үзүүлэх нь” сургалт юм. Австрийн Улаан Загалмайн Нийгэмлэг¹ сургалтын агуулгын зөвлөхөөр ажилласан байна. Найман модуль бүхий энэхүү сургалтыг цахим интерактив агуулгыг судлахын зэрэгцээ танхимд дадлагажуулах сургалттай хослуулсан байдлаар явуулах нь үр дүнтэй байна.

Холимог сургалтыг мэргэжлийн аливаа сургагч багш дурын суралцах бүлэгт чанартай, үр дүнтэй явуулах арга аргачлалаар хангахын тулд “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих” төслөөс Үндэсний хүмүүнлэгийн байгууллага Монголын Улаан Загалмай Нийгэмлэгтэй хамтран энэхүү гарын авлагыг боловсруулав. Гарын авлага нь “Ажлын байранд анхны тусламж үзүүлэх нь” сэдэвт холимог сургалтыг ажилтан ажиллагсдад танхимын болон цахим байдлаар хүргэх сургагч багш нарт зориулагдсан болно.

Сургалтын модуль тус бүрийн сэдвийн агуулга, зорилго, тухайн сэдвээр танхимд дадлагажуулах сургалт явуулахад шаардагдах үндсэн болон нэмэлт хэрэгслүүд, бататгах асуултууд, танхимд болон онлайн талбарт хийж гүйцэтгэх даалгавруудыг гарын авлагад оруулсан. Цахим ба танхимын сургалтыг хэрхэн “хольж” ашиглах нь суралцах бүлгийн онцлог, хэрэгцээ шаардлага, өндөр хурдын Интернет бүхий компьютеруудтай анги танхимын боломж, суралцагчдын компьютерийн хэрэглээний түвшин, гэртээ болон ажлын байрандаа Интернет ашиглах боломж зэргээс хамаарах тул сургагч багш нөхцөл байдлыг үнэлж, гарын авлагад санал болгож буй холимог хэлбэрүүдээс тохирохыг сонгож ашиглах нь зүйтэй юм.

Сургалтын материалд бодит жишээг гутал, арьс шир боловсруулах үйлдвэрийн орчинд авч үзсэн байгаа ч осол гэмтэл гарах, ослын үед анхны тусламж үзүүлэх арга ажиллагаа нь аль ч салбарт ижил тул сургалтын материалыг дурын салбарт ашиглах боломжтой. Тухайн салбарын онцлогоос хамаарч 8 модулиас хэрэгцээ шаардлагын дагуу сонгон хэрэгжүүлж болох юм.

¹ Австрийн Улаан Загалмайн Нийгэмлэг <https://www.rotekreuz.at/i18n/en>

АГУУЛГА

ӨМНӨХ ҮГ	3
СУРГАЛТЫН ТАНИЛЦУУЛГА	5
СУРГАЛТЫН АГУУЛГА	5
СУРГАЛТЫН ХЭЛБЭР	8
СУРГАЛТЫН ХУГАЦАА	12
СУРГАГЧ БАГШИД ӨГӨХ ЗӨВЛӨМЖ	12
НЭГ. ТАНХИМЫН СУРГАЛТ ЯВУУЛАХ АРГА ЗҮЙ	13
ХОЁР. ЦАХИМ СУРГАЛТ ЯВУУЛАХ АРГА ЗҮЙ	15
ГУРАВ. ХОЛИМОГ СУРГАЛТЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ	18
МОДУЛЬ 1. АНХНЫ ТУСЛАМЖИЙН ХАЙРЦАГ	18
МОДУЛЬ 2. ЗҮРХНИЙ ШИГДЭЭСИЙН ҮЕД АНХНЫ ТУСЛАМЖ ҮЗҮҮЛЭХ	21
МОДУЛЬ 3. ТҮЛЭГДЭХ ҮЕД АНХНЫ ТУСЛАМЖ ҮЗҮҮЛЭХ	23
МОДУЛЬ 4. ХИМИЙН ОСЛЫН ҮЕД АНХНЫ ТУСЛАМЖ ҮЗҮҮЛЭХ	25
МОДУЛЬ 5. БИТҮҮ БЭРТЭХ ҮЕД ҮЗҮҮЛЭХ АНХНЫ ТУСЛАМЖ	27
МОДУЛЬ 6. НҮД ГЭМТЭХ ҮЕД АНХНЫ ТУСЛАМЖ ҮЗҮҮЛЭХ	29
МОДУЛЬ 7. ЦУС АЛДАХ ҮЕД АНХНЫ ТУСЛАМЖ ҮЗҮҮЛЭХ	31
МОДУЛЬ 8. ЦАХИЛГААНЫ ОСЛЫН ҮЕД ҮЗҮҮЛЭХ АНХНЫ ТУСЛАМЖ	34
ДӨРӨВ. ЦАХИМ ТАЛБАР ДАХЬ БАГШИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА	36
4.1 НУУЦ ҮГЭЭ СЭРГЭЭХ	36
4.2 ПРОФАЙЛДАА ЗУРАГ, МЭДЭЭЛЭЛ ОРУУЛАХ	38
4.3 ХЭЛЭЛЦҮҮЛЭГТ БИЧИХ	40
4.4 ДААЛГАВАРТ ЗӨВЛӨМЖ ХАРИУ ӨГӨХ	41
4.5 ЦАХИМ ТАЛБАРТ СУРАЛЦАГЧДЫН ЯВЦЫГ ХАРАХ	43
4.6 СУРАЛЦАГЧДАД ЗУРВАС ИЛГЭЭХ	48

СУРГАЛТЫН ТАНИЛЦУУЛГА

“Ажлын байранд анхны тусламж үзүүлэх” сургалт нь модульд суурилсан, интерактив цахим агуулга бүхий сургалт юм. Модульт сургалт учраас суралцах бүлгийн хэрэгцээ шаардлагаас хамаарч дурын 3, эсвэл 5 гэх мэт хэдэн ч модулийг сонгож ашиглах боломжтой. Суралцагч өндөр хурдын Интернэт бүхий гар утас, таблет, зөөврийн болон суурин компьютер ашиглан, хүссэн цагтаа хүссэн газраасаа цахим талбарт нэвтэрч хичээлийн агуулгыг өөрийн хурдаар үзэж судлах боломжтойгоороо онцлог юм. Суралцагч зөвхөн цахим агуулгыг үзэж судлах нь хангалтгүй бөгөөд бэлтгэгдсэн сургагч багш бүхий танхимын дадлагажуулах сургалтанд хамрагдаж байж Гэрчилгээ авна. Сургалтын агуулгыг суралцагч цахим талбартаа орж хүссэн цагтаа бататган сэргээж болно.

Сургалтын зорилго

Ажлын байранд анхны тусламж үзүүлэх холимог сургалтад найман модуль багтсан. Эдгээр модулиуд нь:

- Арьс шир, гутлын үйлдвэрт аливаа осол гэмтэл үүсгэж болох аюулгүй байдлын эрсдлүүдийг таниулах
- Тэдгээр аюул эрсдлээс сэргийлэх аюулгүй ажиллагааны арга хэмжээнүүдийг тайлбарлах
- Гэмтэж бэртсэн хүнд үзүүлэх анхны тусламжийн алхмуудыг нэг бүрчлэн тайлбарлаж ойлгуулах
- Ажлын байранд байх Анхны тусламжийн иж бүрдэлд зайлшгүй байх хэрэгслүүдийг танилцуулах зорилготой.

СУРГАЛТЫН АГУУЛГА

Сургалт нь дараах 8 модулиас бүрдсэн. Үүнд:

- Модуль 1: Анхны тусламжийн хайрцаг
- Модуль 2: Зүрхний шигдээсийн үед анхны тусламж үзүүлэх
- Модуль 3: Түлэгдэлтийн үед анхны тусламж үзүүлэх
- Модуль 4: Химийн ослын үед анхны тусламж үзүүлэх
- Модуль 5: Битүү бэртэх үед анхны тусламж үзүүлэх
- Модуль 6: Нүд гэмтэх үед анхны тусламж үзүүлэх
- Модуль 7: Цус алдалтын үед анхны тусламж үзүүлэх
- Модуль 8: Цахилгааны ослын үед анхны тусламж үзүүлэх

Модуль бүр сургалтын тодорхой зорилгод хүргэх практик агуулга, үйлдвэрийн бодит жишээ, эрсдэл ба анхны тусламж үзүүлэх алхмуудыг тайлбарласан видео, өөрийгөө сорих тестүүдээс бүтсэн. Нэг модуль 2-4 бүлэг буюу дэд сэдэв, дунджаар 45 слайд, өөрийгөө сорих 3 тестээс бүтсэн байна. 8 модуль нь нийт 366 интерактив слайд, нэг бүр нь 0:15-2:07 мин хүртэл (нийт 15 минут) үргэлжлэх 22 видеотой (Хүснэгт 1).


Хүснэгт 1. "АЖЛЫН БАЙРАНД АНХНЫ ТУСЛАМЖ ҮЗҮҮЛЭХ НЬ" ЦАХИМ ХИЧЭЭЛИЙН АГУУЛГА

Модуль #	Сэдэв	Дэд сэдвүүд	Үндсэн слайдын тоо	Дэд слайдын тоо	Нийт слайдын тоо	Видео 1	Видео 2	Видео 3	Видео 4	Видео Бүгд
Модуль 1	АНХНЫ ТУСЛАМЖИЙН ХАЙРЦАГ	1.1 Анхны тусламжийн иж бүрдлийн тухай	7	1	8					
		1.2 Шархны боолт болон наалт	8	6	14					
		1.3 Иж бүрдэлд байх ерөнхий зүйлс	7	2	9					
		1.4 Иж бүрдэлд байх тусгай зүйлс	5	3	8					
		Өөрийгөө сорих тест	3		3					
		Модуль ба бүлгийн танилцуулга, тэмдэглэл	3		3					
		Нийт	33	12	45	Видеогүй				
Модуль 2	ЗҮРХНИЙ ШИГДЭЭСИЙН ҮЕД АНХНЫ ТУСЛАМЖ ҮЗҮҮЛЭХ	2.1 Эрсдэл, шинж тэмдэг, урьдчилан сэргийлэх	7	6	13	0:35	0:15			0:50
		2.2 Зүрхний шигдээсийн үед анхны тусламж үзүүлэх	9	4	13	0:21	0:15	0:15	0:30	1:21
		Өөрийгөө сорих тест	3		3					
		Модуль ба бүлгийн танилцуулга, тэмдэглэл	3		3					
		Нийт	22	10	32	6 видео				
Модуль 3	ТҮЛЭГДЭХ ҮЕД АНХНЫ ТУСЛАМЖ ҮЗҮҮЛЭХ	3.1 Ажлын байрны аюулгүй ажиллагаа: Түлэгдэлт	7	12	19	0:48				0:48
		3.2 Үйлдвэрийн бодит жишээ	1	2	3					
		3.3 Түлэгдэх үед анхны тусламж үзүүлэх	9	8	17	1:21				1:21
		Өөрийгөө сорих тест	4		4					
		Модуль ба бүлгийн танилцуулга, тэмдэглэл	3		3					
		Нийт	24	22	46	2 видео				
Модуль 4	ХИМИЙН ОСЛЫН ҮЕД АНХНЫ ТУСЛАМЖ ҮЗҮҮЛЭХ	4.1 Ажлын байрны аюулгүй ажиллагаа: Химийн бодис	9	12	21	0:49	0:21			1:10
		4.2 Арьс химийн бодист түлэгдэх	9	6	15	0:40				0:40
		4.3 Залгиж хордох	9	4	13	0:40				0:40
		4.4 Амьсгалж хордох	9	10	19	0:55				0:55
		Өөрийгөө сорих тест	3		3					
		Модуль ба бүлгийн танилцуулга, тэмдэглэл	3		3					
		Нийт	42	32	74	5 видео				
						3:25				

Модуль 5	БИТҮҮ БЭРТЭХ ҮЕД АНХНЫ ТУСЛАМЖ ҮЗҮҮЛЭХ	5.1 Ажлын байрны аюулгүй байдал: Битүү бэртэл	7	13	20	0:56			0:56	
		5.2 Үйлдвэрийн бодит жишээ	1	2	3					
		5.3 Битүү бэртэх үед анхны тусламж үзүүлэх	9	3	12	2:07			2:07	
		Өөрийгөө сорих тест	3		3					
		Модуль ба бүлгийн танилцуулга, тэмдэглэл	3		3					
	Нийт	23	18	41		2 видео		3:03		
Модуль 6	НҮД ГЭМТЭХ ҮЕД АНХНЫ ТУСЛАМЖ ҮЗҮҮЛЭХ	6.1 Ажлын байрны аюулгүй байдал: Нүд гэмтэх	5	8	13					
		6.2 Үйлдвэрийн бодит жишээ	1	2	3					
		6.3 Нүд гэмтэх үед анхны тусламж үзүүлэх	9	7	16					
		Өөрийгөө сорих тест	3		3					
		Модуль ба бүлгийн танилцуулга, тэмдэглэл	3		3					
	Нийт	21	17	38		Видеогүй				
Модуль 7	ЦУС АЛДАХ ҮЕД АНХНЫ ТУСЛАМЖ ҮЗҮҮЛЭХ	7.1 Ажлын байрны аюулгүй байдал: Цус ихээр алдах	7	14	21	0:50			0:50	
		7.2 Үйлдвэрийн бодит жишээ	1	2	3					
		7.3 Цус алдах үед анхны тусламж үзүүлэх	9	5	14	1:40			1:40	
		Өөрийгөө сорих тест	5		5					
		Модуль ба бүлгийн танилцуулга, тэмдэглэл	3		3					
	Нийт	25	21	46		2 видео		2:30		
Модуль 8	ЦАХИЛГААНЫ ОСЛЫН ҮЕД АНХНЫ ТУСЛАМЖ ҮЗҮҮЛЭХ	8.1 Ажлын байрны аюулгүй байдал: Цахилгааны осол	7	11	18	0:50			0:50	
		8.2 Үйлдвэрийн бодит жишээ	1	3	4					
		8.3 Цахилгааны ослын үед анхны тусламж үзүүлэх	9	7	16	0:21	0:15	0:15	0:42	1:33
		Өөрийгөө сорих тест	3		3					0
		Модуль ба бүлгийн танилцуулга, тэмдэглэл	3		3					0
	Нийт	23	21	44	5 видео (давхацсан 3)			2:23		
8 МОДУЛЬ НИЙТ		213	153	366		22 видео (давхацсан 3)		15:41		



СУРГАЛТЫН ХЭЛБЭР

Сургалтын зорилго нь ажлын байранд анхны тусламж үзүүлэх онолын мэдлэгийг дадлагатай хослуулан эзэмшүүлэх учраас сургалтыг цахим ба танхимд хослуулсан байдлаар явуулах шаардлагатай. Цахим ба танхимын сургалтыг хэрхэн “хольж” ашиглах нь суралцах бүлгийн онцлог, хэрэгцээ шаардлага, өндөр хурдын Интернэт бүхий компьютеруудтай анги танхимын боломж, суралцагчдын компьютерийн хэрэглээний түвшин, гэртээ болон ажлын байрандаа Интернэт ашиглах боломж зэргээс хамаарах тул сургагч багш нөхцөл байдлыг үнэлж, дараах хүснэгтэд санал болгож буй холимог хэлбэрүүдээс тохирохыг сонгож ашиглах нь зүйтэй (Хүснэгт 2).





Зураг 1. Холимог сургалтыг хэрэгжүүлэх загвар

Хүснэгт 2. НУБАУХБ-ЫН ИНТЕРАКТИВ СУРГАЛТЫН МАТЕРИАЛЫГ АШИГЛАН СУРГАЛТ ЯВУУЛАХ ХЭЛБЭРҮҮД

№	Сургалтын хэлбэр	Тайлбар	Давуу тал	Сул тал
1	 Танхимын сургалт	Багш Интернэтэд холбогдсон компьютер ашиглан, интерактив сургалтын агуулгыг дэлгэцэнд гарган ярьж тайлбарлана. Модулийн агуулгаар дадлага хийлгэнэ.	Суралцагчийн тоогоор өндөр хурдын Интернэт бүхий компьютер шаардахгүй.	Интерактив сургалтын агуулгыг суралцагч өөрөө оролдож суралцах, цахим талбарт түүх үлдээх боломжгүй. Интерактив агуулга нь ердийн PPT үзүүлэн слайдаас ялгаагүй болж хувирна.
2	----- Цахим сургалт	Суралцагч цахим талбарт бие даан суралцана (цахим багшийн дэмжлэгтэй, эсвэл дэмжлэггүй байж болно).	Суралцагч интерактив сургалтын материалыг хүссэн цагтаа, хүссэн газраасаа өөрийн хурдаар, сонирхолтойгоор үзэж судална.	Анхны тусламж үзүүлэх, булчин/судас тариа хийх, гагнуур хийх, үс засах гэх мэт мэдрэхүй шаардсан, багшийн дэмжлэг шаардсан дадлага ажил хийх боломжгүй.
Холимог сургалтын хэлбэрүүд				
1	 ----- Цахим + Танхим	Суралцагч цахим талбарт бие даан суралцаад (цахим багшийн дэмжлэгтэй, эсвэл дэмжлэггүй байж болно), сургалтын төгсгөлд танхимд ирж дадлагажуулах сургалтанд хамрагдана. Цахим талбарт суралцсан байдлыг танхимын сургалт эхлэхээс өмнө багш үнэлж дүгнэсэн байна.	Танхимын сургалтын цаг багасна. Суралцагч интерактив сургалтын материалыг хүссэн цагтаа, хүссэн газраасаа өөрийн хурдаар, сонирхолтойгоор үзэж судална. Өөрийгөө төстээр сорино. Хэлэлцүүлэг дэх эргэцүүлэн бодох асуултуудад хариулна. Цахим талбарт суралцах дадал чадвартай болно.	Суралцагчаас цахим талбарт бие даан суралцах дадал чадвар, сахилга бат шаардана.

2	 <p>Танхим + Цахим</p>	<p>Сургалтын эхэнд бүх суралцагчдыг танхимд цуглуулж, цахим талбарт хэрхэн нэвтрэх, хэрхэн суралцахыг заана. Модулиудын агуулгыг багш интерактив сургалтын агуулгыг ашиглан танхимд түргэвчилсэн байдлаар заана. Бүх дэдлага ажлыг хийлгэнэ. Танхимын сургалтын дараа суралцагчид цахим талбарт үргэлжлүүлэн суралцаж (цахим багшийн дэмжлэгтэй, эсвэл дэмжлэггүй байж болно), хичээлийн агуулгыг өгсөн хугацаанд нарийвчлан судлахаас гадна хэлэлцүүлэгт оролцож, тест бөглөж, даалгавар хийнэ. Танхимын дэдлагажуулах сургалтанд оролцсон байдал, цахим талбарт суралцсан байдлыг багш үнэлж дүгнээд Гэрчилгээ олгох эсэхийг шийдвэрлэнэ.</p>	<p>Танхимын сургалтын цаг багасна. Цахим талбарт хэрхэн суралцахыг сургалтын эхэнд суралцагч танхимд ирж заалгаснаар өөртөө илүү итгэлтэй суралцана. Интерактив сургалтын материалыг хүссэн цагтаа, хүссэн газраасаа өөрийн хурдаар, сонирхолтойгоор үзэж судална. Цахим талбарт суралцах дадал чадвартай болно.</p>	<p>Цахим талбарт интерактив агуулгыг суралцагч өөрийн хурдаар үзэж судлахаасаа өмнө дэдлагажуулах сургалтанд хамрагдах нь дарааллын хувьд сайнгүй. Суралцагчаас цахим талбарт бие даан суралцах дадал чадвар, сахилга бат шаардана.</p>
3	 <p>Цахим + Танхим + Цахим</p>	<p>Суралцагч цахим талбарт бие даан суралцаад (цахим багшийн дэмжлэгтэй, эсвэл дэмжлэггүй байж болно), сургалтын дунд танхимд ирж дэдлагажуулах сургалтанд хамрагдана. Танхимын сургалтын дараа цахим талбарт өгсөн хугацаанд үргэлжлүүлэн суралцана (цахим багшийн дэмжлэгтэй, эсвэл дэмжлэггүй байж болно). Цахим талбарт суралцсан байдал, танхимын дэдлагажуулах сургалтанд оролцсон байдлыг багш үнэлж дүгнээд Гэрчилгээ олгох эсэхийг шийдвэрлэнэ.</p>	<p>Танхимын сургалтын цаг багасна. Суралцагч интерактив сургалтын материалыг хүссэн цагтаа, хүссэн газраасаа өөрийн хурдаар, сонирхолтойгоор үзэж судална. Өөрийгөө тестээр сорино. Хэлэлцүүлэг дэх эргэцүүлсэн бодох асуултаудад хариулна. Цахим талбарт суралцах дадал чадвартай болно.</p>	<p>Суралцагчаас цахим талбарт бие даан суралцах дадал чадвар, сахилга бат шаардана.</p>

4	 <p>Танхим + Цахим + Танхим = Сэндвич</p>	<p>1-3 сар үргэлжлэх сургалтанд тохиромжтой. Сургалтын эхэнд бүх суралцагчдыг танхимд цуглуулж, цахим талбарт хэрхэн нэвтрэх, хэрхэн суралцахыг заана. Суралцагчид өгсөн хугацаанд цахим талбарт үргэлжлүүлэн суралцаж (цахим багшийн дэмжлэгтэй, эсвэл дэмжлэггүй байж болно), хичээлийн агуулгыг нарийвчлан судлахаас гадна хэлэлцүүлэгт оролцож, тест бөглөж, даалгавар хийнэ. Сургалтын төгсгөлд танхимд цуглаж хичээлийн агуулга, хэлэлцүүлэг, даалгаврын үр дүнг ярилцахын хамт дадлага ажил хийнэ. Цахим талбарт суралцсан байдал, танхимын дадлагуулах сургалтанд оролцсон байдлыг багш үнэлж дүгнээд Гэрчилгээ олгох эсэхийг шийдвэрлэнэ.</p>	<p>Үр дүнтэй сургалт. Сургалтын эхэнд ба төгсгөлд нүүр тулж уулзах нь суралцагчдын идэвх сэдлийг төрүүлдэг. Цахим талбарт хэрхэн суралцахыг сургалтын эхэнд суралцагч танхимд ирж заалгаснаараа өөртөө илүү итгэлтэйгээр суралцана. Интерактив сургалтын материалыг хүссэн цагтаа, хүссэн газраасаа өөрийн хурдаар, сонирхолтойгоор үзэж судална. Цахим талбарт суралцах дадал чадвартай болно.</p>	<p>Суралцагчаас цахим талбарт бие даан суралцах дадал чадвар, сахилга бат шаардана.</p>
5	 <p>Танхим + Цахим + Танхим + Цахим + Танхим = Давхар СЭНДВИЧ</p>	<p>6 сар, түүнээс дээш хугацаагаар үргэлжлэх сургалтанд тохиромжтой.</p>	<p>Танхимын сургалтын цаг багасна. Суралцагч интерактив сургалтын материалыг хүссэн цагтаа, хүссэн газраасаа өөрийн хурдаар, сонирхолтойгоор үзэж судална. Цахим талбарт суралцах дадал чадвартай болно.</p>	<p>Сургалтын байгууллагаас хүчин чармайлт их шаардана.</p>

СУРГАЛТЫН ХУГАЦАА

Холимог сургалтын үргэлжлэх хугацаа 21 цаг (60 минутаар). Үүнээс танхимд 13 цаг, онлайнаар 8 цаг хичээллэнэ. Суралцах бүлгийн онцлог, хэрэгцээ шаардлагаас хамаарч сургалтын цагийг багш өөрчлөн хэрэгжүүлэх боломжтой.

Суралцагч танхимд болон цахим байдлаар модулиудыг судалж, модуль бүрд өгөгдсөн дадлага ажлуудыг гүйцэтгэн, хэлэлцүүлгийн асуултуудад хариулах ба тестээр өөрийгөө сорино. Сургалтыг амжилттай дүүргэсэн суралцагч сертификат авах юм.

Хүснэгт 3. "АЖЛЫН БАЙРАНД АНХНЫ ТУСЛАМЖ ҮЗҮҮЛЭХ НЬ" ХОЛИМОГ СУРГАЛТЫН ЦАГ

Модуль	Танхимд, цаг			Онлайн, цаг			Нийт цаг
	Онол	Дадлага	Нийт	Онол	Дадлага	Нийт	
М1	0.5	1.0	1.5	0.5	0.5	1.0	2.5
М2	0.5	1.0	1.5	0.5	0.5	1.0	2.5
М3	0.5	1.0	1.5	0.5	0.5	1.0	2.5
М4	0.5	1.0	1.5	0.5	0.5	1.0	2.5
М5	0.5	1.0	1.5	0.5	0.5	1.0	2.5
М6	0.5	1.0	1.5	0.5	0.5	1.0	2.5
М7	1.0	1.0	2.0	0.5	0.5	1.0	3.0
М8	1.0	1.0	2.0	0.5	0.5	1.0	3.0
Нийт	5.0	8.0	13.0	4.0	4.0	8.0	21.0

СУРГАГЧ БАГШИД ӨГӨХ ЗӨВЛӨМЖ

Танхимд болон цахим талбарт сургалтыг хөтлөн явуулах нь багшаас ялгаатай ур чадваруудыг шаарддаг. Танхимд багш сайн илтгэгч, харилцагч, зохион байгуулагч байх шаардлагатай байдаг. Цахим багш суралцагчдын хоорондох орон зай, цаг хугацааны зайг нөхөх гүүр болж, дэлгэцний ард суун суралцаж буй хүнийг болзошгүй ганцаардал, бухимдлаас сэргийлсэн тактик боловсруулах, үр дүнд чиглэсэн бүтээмжит сургалт болоход дэмжлэг үзүүлэх шаардлагатай. Багш цахимаар харилцаанд, агуулгад, зохион байгуулалтад дэмжлэг үзүүлж ажиллана. Үүний тулд сургагч, дасгалжуулагч, идэвхжүүлэгч, зохион байгуулагчийн ажил үүргийг гүйцэтгэх юм.



ТАНХИМЫН СУРГАЛТ ЯВУУЛАХ АРГА ЗҮЙ

Сургагч багш нар сургалт эхлэхийн өмнө өөрийгөө танилцуулж, суралцагчдыг сургалтад анхаарлаа сайтар хандуулахыг урих нь чухал байдаг. Ингэхдээ өөрийн нэр, ажил болон ажлын туршлагаа товч танилцуулах хэрэгтэй.

Асуулт/Хэлэлцүүлэг

Сургалт эхлэхийн өмнө болон үеэр суралцагчдын дунд дараах ерөнхий асуултуудыг тавьж хэлэлцүүлэг явуулах нь “Ажлын байранд анхны тусламж үзүүлэх” сургалтад оролцогчдын анхаарлыг төвлөрүүлэх чухал алхам болох юм:

Анхны тусламжийн талаар

- Та хэн нэгэнд анхны тусламж үзүүлж байсан тохиолдол байгаа юу?
- Тийм бол тусламж нь хэр үр дүнтэй болж байсан бэ? Туршлагаасаа хуваалцана уу.

Аюулгүй байдлын эрсдлүүдийн талаар

- Та ажлын байрандаа аюулгүй байдлын ямар эрсдлүүдтэй нүүр тулгарч байсан бэ?
- Та өдөр тутмын ажлаа хэрхэн аюулгүйгээр гүйцэтгэдэг вэ? Туршлагаасаа хуваалцана уу.

Аюулгүй ажиллагааны арга хэмжээний талаар

- Таны ажлын байрыг аюулгүй болгох ямар арга хэмжээнүүдийг та мэдэх вэ?
- Та тэдгээр арга хэмжээ болон бусад ямар хэрэгслийг ажилдаа ашигладаг вэ?
- Аюулгүй ажиллахад болон аюулыг даван туулахад саад болдог зүйлс юу байж болох вэ?

Дээрх асуултуудыг сургалтын эхэнд оролцогчдын дунд тавьж, товчхон хэлэлцүүлэг явуулах ба модулиудын бүлэг тус бүрд дээрх 3 чиглэлээр хэлэлцүүлгийн нарийвчилсан асуултуудыг санал болгосон байгаа.

Даалгавар/дадлага ажил

Модуль тус бүрд танхимд болон онлайнаар гүйцэтгэх даалгавруудыг чиглүүлэх талаар зааварчилгаа оруулсан бөгөөд энэ нь оролцогчдыг илүү бүтээлчээр, оролцоонд суурилсан дадлага ажил хийж ур чадвар олж авахад нь туслах юм.

Тохиолдол дээр суурилсан дадлага ажлуудыг хийлгэхдээ үйлдвэр, ажлын байранд тохиолдож болохуйц, бодит тохиолдлуудыг сонгон авах, оролцогчдыг идэвхтэй оролцуулах зорилгоор өөрсдөөр нь тохиолдлуудыг зохиолгох, бүлэгт байгаа суралцагч бүрийн тэгш оролцоог хангах нь чухал.

Тохиолдол дээр суурилсан бүлгийн дадлага ажил нь:

1. **Жүжигчилсэн байдлаар** буюу ямар нэг ослын тохиолдолд оролцогчид дүрүүдийг хуваарилан авч, дүрд тоглох. Осолдогч, ослын анхны гэрч, мэдээлэгч, ахлах ажилтан, анхны тусламж үзүүлэгчид гэх мэт дүрүүдийг хуваарилан, үзүүлэх тоглолт байдлаар хийх.
2. **Зааварчилгаа өгөх байдлаар** буюу бүлгээс хэн нэг нь сонгогдон, тухайн ослын тохиолдлын үед бусад оролцогчдод анхны тусламж үзүүлэх алхмуудыг нэг бүрчлэн зааж хийлгэх.
3. **Асууж чиглүүлэх байдлаар** буюу сургагч багш оролцогчдын сонгосон тохиолдол дээр дараагийн хийх анхны тусламжийн алхмуудыг асууж, алдааг залруулан дуусгах

гэсэн хэлбэрүүдээр байж болох ба бүлгийн ажил болгоны дараа нийт бүлэгт хандаж бүлгийн ажлын үед юу нь зөв болон буруу байсан талаар асууж санал солилцох нь зүйтэй. Эцсийн дүгнэлтийг сургагч багш өөрөө хийж, бүлгийн ажлын үед гарсан алдаатай зүйлсийг хэлж ойлгуулах байдлаар сургалтыг явуулна.

2

ЦАХИМ СУРГАЛТ ЯВУУЛАХ АРГА ЗҮЙ

Цахим сургалтын талбар дахь профайлдаа өөрийн танилцуулга, ажлын туршлагын талаарх мэдээлэл, цээж зургаа оруулсан байна. Суралцагчид сургалтын талбартай танилцах явцад тэдэнд технологийн дэмжлэг хэрэгтэй болдог. Тэд ихэвчлэн анхны удаа цахим сургалтанд оролцож байх тул суралцах, харилцах энэхүү шинэ хэлбэрийн анхлан үзэж мэдэрдэг. Багш тэднийг зоригжуулж, талбарын бүтцийг танилцуулан, шаардлагатай бол цахим сургалтын давуу талуудыг хэлж өгөх хэрэгтэй.

Сургалт эхлэх үед

- 1) Сургалтын эхэнд талбар дахь “Зар мэдээлэл” хэлэлцүүлэгт (News Forum) өөрийгөө танилцуулна. Тухайлбал ажлын туршлага, сургалт/ цахим сургалтын туршлага, түүнчлэн суралцагчийн асуултанд 48 цагийн дотор хариулах болно гэдгээ мэдээнэ.
- 2) “Ерөнхий хэлэлцүүлэг”-т (General Forum) өөрийгөө танилцуулахыг суралцагчдаас хүснэ. Сонирхолтойгоор танилцахын тулд “Та дуртай, дургүй 3 зүйлээ бичнэ үү” гэх мэт асуулт оруулж болно. Мөн сургалтаас ямар үр дүн хүлээж буйг нь асуух хэрэгтэй. Тухайлбал: “Та энэ сургалтанд суралцсанаар юуг өөрөөр хийдэг болохыг хүсч байна вэ?” гм.
- 3) “Ажлын байранд анхны тусламж үзүүлэх” цахим сургалтын талаар танилцуулж, хэлэлцүүлэгт хэрхэн оролцох болон даалгавруудын талаар тайлбарлана.
- 4) “Ерөнхий хэлэлцүүлэг”-т хэлэлцүүлгийн эхний асуултыг оруулна.
- 5) Суралцагч хэлэлцүүлэгт асуулт оруулмагц 48 цагийн дотор хариулна. Эсвэл бусад суралцагчдыг тухайн асуултанд хариулахыг уриалж, 48 цагийн хугацаа өгч болно. Хэрэв энэ хугацаанд зөв хариулт ирэхгүй бол өөрөө хариулна.

Сургалтын явцад

- 1) “Зар мэдээлэл” хэлэлцүүлэгт модулийн сэдвийг танилцуулж, даалгаврыг хийж гүйцэтгэх сүүлийн хугацааг бичнэ. Суралцагчдын анхаарлыг татахын тулд модулийн эхний өдөр “Модуль 1 эхэлж байна” гэх байдлаар бичиж явна.
- 2) Модулийн хэлэлцүүлэгт хичээлийн агуулгатай холбоотой эхний асуултыг оруулна.
- 3) Даалгаврын хугацаа дөхөж байгааг суралцагчдад 5 хоногийн өмнө сануулж бичнэ.
- 4) Модулийг судалж дуусахаас өмнө модулийн үр дүнг хэлэлцүүлэгт нэгтгэн дүгнэнэ. Тухайлбал “Модуль 1-ээс гарсан үр дүн” гэсэн хэлхээ нээж оруулж болно.
- 5) Суралцагч бүр даалгавраа хийж талбарт оруулсан эсэхийг шалгана. Хэрэв амжаагүй хүн байвал аль болох хурдан, даалгаврын хугацаанаас хойш нэг хоногоос хэтрэлгүй холбогдож сануулна.

- б) Суралцагч бүрийн даалгаварт зөвлөмж хариу өгнө. Үүнийг даалгаврын хугацаанаас хойш 7 хоногийн дотор гүйцэтгэн, хариу файлаа Даалгаварт оруулж суралцагчдад мэдээлнэ.

Харилцаа холбоо

Сургагч багш харилцаанд маш идэвхтэй байж, суралцагчдаас имэйлээр болон хэлэлцүүлэгт ирэх асуултанд 48 цагийн дотор хариулах ёстой. Хэрэв бүх нийтийн амралтын өдөр, уртасгасан амралтын өдрүүд таарвал багш эзгүй байх тухайгаа, мөн хэзээнээс асуултанд хариулж эхлэхийгээ амралтаас 24 цагийн өмнө мэдэгдэх хэрэгтэй.

Сургалтын чухал зар мэдээллүүдийг багш “Зар мэдээлэл” хэлэлцүүлэгт тухай бүр оруулна. Энэ нь оролцогчдын имэйл хаяг руу автоматаар илгээгдэхийн зэрэгцээ талбарын “Сүүлд нэмэгдсэн зар” буланд ил харагдаж байдаг давуу талтай.

Сургагч багш оролцогчдоо үлгэрлэж, холбоо харилцаанд зөвхөн цахим талбараа ашиглах ёстой. Бүх оролцогч, эсвэл бүлэг оролцогчид хандсан асуулт, хариултыг хэлэлцүүлэгт бичнэ. Ингэснээр энэ мэдээлэл оролцогч бүрд байнга нээлттэй байх юм. Хувь хүнд хандсан асуулт, хариултыг “Зурвас” хэсгийг ашиглан илгээнэ. Бүх оролцогчдын жагсаалтаас тухайн нэг, эсвэл хэдэн оролцогчийн нэрийг идэвхжүүлээд, “Зурвас илгээх” гэдгийг сонгоод бичнэ.

“Зар мэдээлэл” хэлэлцүүлэгт оруулах мэдээллүүд:

- **“Тавтай морилно уу” зурвас:** Сургагч багшийг танилцуулах, суралцагчдыг цахим сургалтад урих
- **Модулийн тухай:** Модуль эхэлж буйг мэдэгдэх, судлах гол асуудлууд/ хичээлийн зорилго, даалгаврууд ба хугацаа, цахим семинар/ чатын товыг мэдээлэх
- **Даалгавар No.# гүйцэтгэх тухай сануулга:** Даалгавар гүйцэтгэх сүүлийн хугацааг уг өдрөөс 5 хоногийн өмнө сануулах
- **Хэлэлцүүлэгт урих:** Тодорхой сэдэвт хэлэлцүүлэгт бүх оролцогчдыг урих. Ингэхдээ хэлэлцүүлэг рүү очих холбоос оруулахаа мартуузай.

Модулийн хэлэлцүүлэгт оруулах мэдээллүүд нь:

- Модулийн агуулгын гол сэдвийг хөндсөн нэг чухал асуулт асуух
- Хэрэгтэй гэж үзвэл модулийн агуулгыг практиктай холбосон, хэлэлцүүлэг яриаг өрнүүлэхэд тус болох хоёр дахь асуултыг тавьж болно.
- Оролцогчдын асуултад хариулах
- Модулийн төгсгөлд даалгавруудыг хэн нэг оролцогчийн нэрийг онцлохгүйгээр ерөнхийд нь нэгтгэн дүгнэх, модулиас сурч мэдсэн зүйлсийг дүгнэх

Суралцагчдыг үнэлэх

Оролцогчдын гүйцэтгэлийг цахим талбарт тогтмол шалгаж байх нь хэн нэг нь хоцорч байхаас сэргийлэх амин чухал үүрэгтэй. Сургагч багш “Даалгавар” хэсгийн “Зөвлөмж хариу өгөх” холбоосыг ашиглан даалгавар бүрд хариу өгнө. Мөн хэлэлцүүлэгт оролцож асуудал дэвшүүлж байгаа байдлаар нь оролцогчдод оноо өгч болох юм.

Багш бүтээлч зөвлөмж хариу хэрхэн өгөх вэ?	
Дүрэм 1.	Талархсан, нөхөрсөг, сэдэл идэвхжүүлсэн үгс хэрэглэх
Дүрэм 2.	Зөвхөн алдааг нь дөвийлгөлгүйгээр даалгаврыг хэрхэн сайжруулах тодорхой зөвлөмж бичиж, даалгаврын юу нь, яагаад сайн байсныг хэлж өгөх
Дүрэм 3.	Даалгаврыг бүрэн биелүүлсэн эсэхийг үнэлэх тодорхой шалгуурууд ашиглах

Даалгаварт оноо ба зөвлөмж хариу өгөхдөө дараах үзүүлэлтүүдийг ашиглаж болно. Үүнд:

- Даалгаврыг зорилго юу вэ? Оролцогч даалгавраа сайн ойлгосон уу?
- Энэхүү даалгавар нь модулийн ерөнхий зорилготой хэрхэн холбогдож байгаа вэ? Оролцогчийн хийсэн даалгавар модулийн сургалтын зорилгыг биелүүлсэн эсэхийг нь харуулж чадаж байна уу?
- Даалгавраар сургалтын ямар зорилго, шалгуурыг хангуулахыг зорьсон бэ? Үүнийг хангахын тулд юу хийх шаардлагатай байсан бэ?

Хэлэлцүүлэгт бичих жишээ

Жишээ 1. “Зар мэдээлэл” хэлэлцүүлэгт бичих

Гарчиг: Сургалтад тавтай морилно уу!

Сайн байцгаана уу,

“Ажлын байранд анхны тусламж үзүүлэх нь” холимог сургалтад тавтай морилно уу. Энэхүү сургалтын гол зорилго нь ажлын байранд гэмтэл үүсгэх эрсдлүүдийг таньж мэдэх, тэдгээрээс сэргийлэх аргууд, гэмтсэн үед анхны тусламж үзүүлэх мэдлэг, ур чадвар олж авах юм.

Танд энэхүү сургалтыг (нэр, мэргэжлийн туршлага) сургагч багш чиглүүлэн хүргэнэ. Багш таны асуултад 48 цагийн дотор хариулах болно. Ерөнхий хэлэлцүүлэгт та сургалтын талаар асууж лавлах зүйлсээ бичээрэй. Модуль тус бүрд хэлэлцүүлэг байгаа ба та тэнд тухайн модулийн агуулгатай холбоотой ярилцах зүйлсээ оруулна. Сургалтын цахим талбарынхаа хэсэг бүрд орж, сайтар танилцаарай.

Сургалтыг амжилттай төгсөхийн тулд та дараах зүйлсийг хийж гүйцэтгэх юм. Үүнд:

- Модуль бүрийн агуулгыг үзэж судлах
- Даалгаврууд хийх
- Хэлэлцүүлэгт оролцох
- Шалгалтыг амжилттай өгөх эдгээр болно.

Сургалтын чухал мэдээллүүдийг багш энэхүү “Зар мэдээлэл” хэлэлцүүлэгт оруулж байх болно.

Таныг энэхүү сургалтыг амжилттай дүүргэж, цахимаар суралцах туршлагаа арвижуулна гэдэгт итгэж байна.

Мэндчилсэн,

... (багшийн нэр)

Жишээ 2. Ерөнхий хэлэлцүүлэгт бичих

Гарчиг: Сургалтаас хүлээж байгаа зүйлс

Сайн байцгаана уу,

Суралцагчдынхаа хүлээлтийг ойлгож мэдэх нь сургалтыг амжилттай явуулахад чухал ач холбогдолтой билээ. Иймд суралцагч бүр дараах асуултад хариулна уу:

Та энэхүү сургалтаас юуг хүлээж байна вэ? Энэ сургалтад оролцож байгаа зорилго тань юу вэ?

“Хариу илгээх” товчийг дарж хариултаа илгээнэ үү.

Баярлалаа,

Багш нь

З

ХОЛИМОГ СУРГАЛТЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ

Модуль тус бүрийг холимог сургалтын аргаар хэрхэн үр дүнтэй явуулах, танхимд болон цахим талбарт багш суралцагчдыг хэрхэн хөтөлж чиглүүлэхийг энэ бүлэгт тайлбарлалаа.



МОДУЛЬ 1

АНХНЫ ТУСЛАМЖИЙН ХАЙРЦАГ

СУРГАЛТЫН ЗОРИЛГО

- Ажлын байранд байх анхны тусламжийн хайрцагт зайлшгүй байх зүйлсийг тоочиж сургах
- Анхны тусламжийн иж бүрдэлд агуулагдах зүйлсийг хэрхэн зөв хэрэглэх талаар мэдлэг, ойлголтыг эзэмшүүлэх.

ХИЧЭЭЛИЙН АГУУЛГА

- Бүлэг 1. Анхны тусламжийн иж бүрдлийн тухай
- Бүлэг 2. Төрөл бүрийн шархны боолт ба наалтуудын талаар
- Бүлэг 3. Иж бүрдэлд байх ерөнхий зүйлс
- Бүлэг 4. Иж бүрдэлд байх тусгай зүйлс
- Бүлэг 5. Өөрийгөө сорих тест

Танхимд дадлагажуулах сургалтанд ашиглах багаж хэрэгсэл, үзүүлэн материал

Зайлшгүй байх зүйлс	Нэмэлтээр байх зүйлс
<ul style="list-style-type: none"> • Том, жижиг хэмжээ бүхий анхны тусламжийн 2 иж бүрдэл • Төрөл бүрийн зориулалттай шархны боолт, наалтууд • Нэг удаагийн бээлий • Дулаацуулах хөнжил • Гар ариутгагч • Хайч • Яаралтай тусламжийн дуудлага өгөх зааварчилгаа 	<ul style="list-style-type: none"> • Нүд угаагч • Хиймэл амьсгал хийхэд зориулагдах ам болон нүүрний хаалт • Автомат дефибриллятор

Танхимд хичээл заахдаа интерактив сургалтын материалыг дэлгэцэнд харуулж байгаад тайлбарлана. Интерактив хичээлийн төгсгөлд байгаа өөрийгөө сорих 3 тестийг хамтран гүйцэтгэж, зөв буруу хариултыг ярилцана.

ХЭЛЭЛЦҮҮЛГИЙН СЭДВҮҮД

Бүлэг 1. Анхны тусламжийн иж бүрдлийн тухай

- Анхны тусламжийн хайрцагт өөр ямар хэрэгсэл байхыг та харж байсан бэ?
- Анхны тусламжийн иж бүрдэлд ямар нэг эм байж болох уу? Яагаад?
- Танай байгууллага анхны тусламжийн хайрцгаа яг хаана байрлуулбал зохимжтой байна вэ? Яагаад?

Бүлэг 2. Төрөл бүрийн шархны боолт ба наалтуудын талаар

- Ямар тохиолдолд шархны ариун наалт болон боолтыг хэрэглэхийг эрмэлзэх вэ?
- Шархаар цус ихээр алдаж байгаа үед анхны тусламжийн хайрцагт хангалттай хэмжээний боолт байхгүй бол та цусыг тогтооход юу ашиглах вэ?

Бүлэг 3. Иж бүрдэлд байх ерөнхий зүйлс

- Анхны тусламжийн хайрцагт хайч яагаад зайлшгүй байх хэрэгтэй вэ?
- Танай ажлын байранд байх анхны тусламжийн хайрцагт зайлшгүй байх шаардлагатай хэрэгсэл юу байж болох вэ?

Бүлэг 4. Иж бүрдэлд байх тусгай зүйлс

- Нүд угаагч зориулалтын шингэн байхгүй үед та ямар шингэнээр орлуулах вэ?
- Хиймэл амьсгал хийх зориулалтын ам болон нүүрний халхавч байхгүй бол юугаар орлуулж болох вэ?

ДААЛГАВАР

Оролцогчдын түвшин, хэрэгцээ шаардлагаас хамаарч дараах даалгавруудаас сонгон хэрэгжүүлж болно:

Танхимд	Онлайнаар
<ol style="list-style-type: none"> 1. Анхны тусламжийн хайрцагт байх ерөнхий болон тусгай хэрэгслүүдийг оролцогчдоор ангилан ялгуулах. 2. Тэдгээр хэрэгслүүдийг тус бүрд нь ямар зориулалтаар хэрэглэхийг нэг бүрчлэн тоочуулах. 3. Шархны лентийг хурууны завсар хооронд, тохойд, хурууны үзүүрт хэрэглэх. Ингэхдээ дэлгэцэнд интерактив хичээлийг харуулж байгаад зааврын дагуу гүйцэтгэх 4. Гурвалжин алчуур ашиглан гар сойж боох 5. Нэг удаагийн бээлийг өмсөж, тайлах 6. Нүд угаагч, хиймэл амьсгал хийхэд зориулагдах ам болон нүүрний хаалт, автомат дефибриллятор ашиглаж турших 	<ol style="list-style-type: none"> 1. Хүснэгт ганцаарчлан бөглөж Даалгаварт оруулах: Байгууллагынхаа анхны тусламжийн хайрцагт байвал зохих 15 зүйлсийн жагсаалтыг хүснэгтэд гаргана уу. 2. Викид бичих бүлгийн даалгавар: Байгууллагад анхны тусламжийн хайрцгийг хариуцдаг хүнтэй байх ёстой талаар бид үзлээ. Тэгвэл энэ хүний гүйцэтгэх ажил үүргүүдийг жагсааж бичнэ үү. 3. Викид бичих ганцаарчилсан даалгавар: Байгууллагад 10-аас дээш хүнтэй цех, тасаг, нэгж бүр анхны тусламжийн 1 хайрцагтай байх ёстой. Танай байгууллагын хувьд анхны тусламжийн хэдэн хайрцаг хэрэгтэй, тэдгээрийг яг хаана, хэрхэн байрлуулбал зохимжтой болохыг жагсааж бичнэ үү. Яагаад энэ байршлыг сонгож байгаагаа тайлбарлаж бичнэ үү. 4. Хэлэлцүүлгийн 8 асуултанд хариулах. Мөн шинээр асуулт оруулж болно. 5. Интерактив хичээлд буй 3 тестийг бөглөх

ШАЛГАЛТ БА ҮНЭЛГЭЭ

Дээрх даалгаврууд болон бүлэг тус бүрийн асуултад хариулсан байдлаар оролцогчдын олж авсан мэдлэгийг шалгана.

ХИЧЭЭЛИЙН ЦАГ

Суралцахуй	Танхимд	Онлайнаар	Нийт
Онол	Багшийн лекц (интерактив агуулгаа ашиглана) 0.5 цаг	Интерактив агуулгыг судлах, тест бөглөх 0.5 цаг	1 цаг
Дадлага	Бүлгээр, эсвэл ганцаарчилсан дадлага, даалгавар хийх 1 цаг	Хэлэлцүүлэгт оролцох, даалгавар хийх 0.5 цаг	1.5 цаг
Нийт	1.5 цаг	1 цаг	2.5 цаг

МОДУЛЬ 2

ЗҮРХНИЙ ШИГДЭЭСИЙН ҮЕД АНХНЫ ТУСЛАМЖ ҮЗҮҮЛЭХ

СУРГАЛТЫН ЗОРИЛГО

- Зүрхний шигдээсийн гол шалтгаануудыг таниулах
- Зүрхний шигдээсийн шинж тэмдгүүдийн талаар мэдлэг, ойлголт өгөх
- Зүрхний шигдээсээс урьдчилан сэргийлэх арга замуудыг таниулах
- Зүрхний шигдээсийн үед анхны тусламж үзүүлэх мэдлэг, ур чадварыг эзэмшүүлэх.

ХИЧЭЭЛИЙН АГУУЛГА

Бүлэг 1. Эрсдэл, шинж тэмдэг, урьдчилан сэргийлэх

Бүлэг 2. Зүрхний шигдээсийн үед анхны тусламж үзүүлэх

Бүлэг 3. Өөрийгөө сорих тест

Танхимд дадлагажуулах сургалтанд ашиглах багаж хэрэгсэл, үзүүлэн материал

Зайлшгүй байх зүйлс	Нэмэлтээр байх зүйлс
<ul style="list-style-type: none"> • Зүрхний шигдээс үүсгэх эрсдэлт хүчин зүйлс болох амьдралын буруу хэв маягийг үзүүлсэн зургууд • Самбар, флипчарт, маркер 	<ul style="list-style-type: none"> • Сургалтад зориулагдсан автомат дефибриллятор • Хиймэл амьсгал хийхэд зориулагдсан ам болон нүүрний хаалт оролцогчдын тоогоор

Танхимд хичээл заахдаа интерактив сургалтын материалыг дэлгэцэнд харуулж байгаад тайлбарлана. Өвчтөнийг байрлуулах, шинжих слайдуудаас гадна цээж дарах иллэг, хиймэл амьсгал хийх, эдгээрийг хослуулан хийх видео зааврыг тоглуулна. Интерактив хичээлийн төгсгөлд байгаа өөрийгөө сорих 3 тестийг хамтран гүйцэтгэж, зөв буруу хариултыг ярилцана.

ХЭЛЭЛЦҮҮЛГИЙН СЭДВҮҮД

Бүлэг 1. Эрсдэл, шинж тэмдэг, урьдчилан сэргийлэх

- Зүрхний шигдээс үүсгэх өөр ямар эрсдэлт хүчин зүйлсийн талаар та мэдэх вэ?
- Зүрхний шигдээстэй адил төстэй шинж тэмдэг бүхий өөр ямар тохиолдлууд байж болох вэ?

Бүлэг 2. Зүрхний шигдээсийн үед анхны тусламж үзүүлэх

- Зүрхний шигдээсийн шинж тэмдэг илэрч ухаан алдсан өвчтөн хэрэв амьсгалтай байгаа тохиолдолд өвчтөнийг ямар байрлалд байлгах нь илүү тохиромжтой вэ?
- Зүрхний хэм тогтворжуулагч автомат багажийг (дефибриллятор) яагаад ажлын байранд байрлуулж болох вэ?

ДААЛГАВАР

Танхимд	Онлайнаар
<ol style="list-style-type: none"> Оролцогчдыг 4-5 хүнтэй бүлэгт хувааж, зүрхний шигдээсээр өвдөх эрсдэлт хүчин зүйлсийн талаар хэлэлцүүлэх. Дээрх бүлгээр зүрхний шигдээсийн тохиолдол дээр суурилсан дадлага ажлыг жүжигчилсэн байдлаар гүйцэтгүүлэх. Ингэхдээ үйлдвэрийн өөр өөр хэсгүүдэд гарч байгаа тохиолдлуудыг сонгон авах. Зориулалтын манекен дээр оролцогч бүрээр ЗУСА (Зүрх уушгины сэхээн амьдруулалт) буюу цээжний даралт, хиймэл амьсгалыг хийлгэж сургах. 	<ol style="list-style-type: none"> Викид бичих бүлгийн даалгавар: Зүрхний шигдээсээс урьдчилан сэргийлэх гол арга зам бол амьдралын зөв хэв маяг билээ. Та тамхинаас гарах, илүүдэл жингээ хасах, өдөр тутам дасгал хөдөлгөөн хийх талаар өөрийн эсвэл бусдын туршлагаас бичиж зөвлөмж өгнө үү. Хэлэлцүүлгийн 4 асуултанд хариулах. Мөн шинээр асуулт оруулж болно. Интерактив хичээлд буй 3 тестийг бөглөх

ШАЛГАЛТ БА ҮНЭЛГЭЭ

Оролцогчдыг зүрхний шигдээсээр өвдсөн өвчтөнд илэрч болох шинж тэмдгүүдийг таних болон анхны тусламж үзүүлэх дараалал, ЗУСА хийх чадвараар нэг бүрчлэн үнэлнэ. Оролцогч бүр ЗУСА-ыг бүрэн, зөв хийж чадаж байх нь үнэлгээний гол шалгуур болно.

ХИЧЭЭЛИЙН ЦАГ

Суралцахуй	Танхимд	Онлайнаар	Нийт
Онол	Багшийн лекц (интерактив агуулгаа ашиглана) 0.5 цаг	Интерактив агуулгыг судлах, тест бөглөх 0.5 цаг	1 цаг
Дадлага	Бүлгээр, эсвэл ганцаарчилсан дадлага, даалгавар хийх 1 цаг	Хэлэлцүүлэгт оролцох, даалгавар хийх 0.5 цаг	1.5 цаг
Нийт	1.5 цаг	1 цаг	2.5 цаг

МОДУЛЬ 3

ТҮЛЭГДЭХ ҮЕД АНХНЫ ТУСЛАМЖ ҮЗҮҮЛЭХ

СУРГАЛТЫН ЗОРИЛГО

- Түлэгдэх осолд хүргэдэг аюулгүй байдлын гол эрсдлүүдийг нэрлэж чаддаг болох
- Түлэгдэх ослоос сэргийлэх аюулгүй ажиллагааны арга хэмжээг таниулах
- Түлэгдэх ослын үед анхны тусламж үзүүлэх мэдлэг, чадварыг эзэмшүүлэх

ХИЧЭЭЛИЙН АГУУЛГА

Бүлэг 1. Ажлын байрны аюулгүй ажиллагаа: Түлэгдэлт

Бүлэг 2. Үйлдвэрийн бодит жишээ

Бүлэг 3. Түлэгдэх үед анхны тусламж үзүүлэх

Бүлэг 4. Өөрийгөө сорих тест

Танхимд дадлагажуулах сургалтанд ашиглах багаж хэрэгсэл, үзүүлэн материал

Зайлшгүй байх зүйлс	Нэмэлтээр байх зүйлс
<ul style="list-style-type: none">• Самбар, флипчарт, маркер• Боолт, ариун наалт, гурвалжин алчуур	<ul style="list-style-type: none">• Түлэнхийн зориулалтын боолт• Хүнсний нийлэг ороолт

Танхимд хичээл заахдаа интерактив сургалтын материал, видеог дэлгэцэнд харуулж байгаад тайлбарлана. Интерактив хичээлийн төгсгөлд байгаа өөрийгөө сорих 4 тестийг хамтран гүйцэтгэж, зөв буруу хариултыг ярилцана.

ХЭЛЭЛЦҮҮЛГИЙН СЭДВҮҮД

Бүлэг 1. Ажлын байрны аюулгүй ажиллагаа: Түлэгдэлт

- Танай ажлын байранд халууны болон химийн бодисын гаралтай түлэгдэлт үүсгэх ямар эрсдлүүд байж болох вэ?
- Тэдгээр эрсдлүүдийг бууруулахын тулд ямар арга хэмжээ авч болох вэ?

Бүлэг 2. Үйлдвэрийн бодит жишээ

- Энэ тохиолдолд аюулгүй байдлын үүднээс таны авах хамгийн эхний алхам юу байж болох вэ?
- Энэ тохиолдолд ажилтны түлэгдсэн гарын хэсгийг юугаар хөргөх нь хамгийн тохиромжтой вэ? Өөр ямар хавсарсан гэмтэл байж болох вэ?

Бүлэг 3. Түлэгдэх үед анхны тусламж үзүүлэх

- Түлэгдсэн хэсгийг нэн даруй хөргөхөд хангалттай хэмжээний урсгал ус ойр байхгүй бол юугаар орлуулж болох вэ?
- Хуурай, нунтаг химийн бодис (хүчил) арьсанд хүрч түлэгдэл үүсгэсэн тохиолдолд тэр бодисыг арьснаас зайлуулах тохиромжтой арга юу байж болох вэ?

ДААЛГАВАР

Танхимд	Онлайнаар
<p>1. Оролцогчдыг 4-5 хүнтэй бүлэгт хуваан, төрөл бүрийн хүчин зүйлээр үүсгэгдсэн түлэгдлийн тохиолдол зохиолгож, анхны тусламж үзүүлэх дадлага хийлгэх. Дадлага ажлын үед нэн тэргүүнд орчны аюулгүй байдлыг шалгаж байгаа эсэхийг сайн анхаарах.</p> <p>2. Хувцсанд гал авалцсан үед шууд ус цацаж унтраах нь ямар эрсдэлтэй байж болохыг хэлэлц. (Хувцсанд гал авалцан дүрэлзэж байгаа үед ус цацаж унтраах нь маш өндөр температуртай уур хувцас, бие 2-ын завсар үүсэж илүү ноцтой түлэгдэл үүсэх аюулыг дагуулдаг)</p>	<p>1. Хэлэлцүүлгийн 6 асуултанд хариулах. Мөн шинээр асуулт оруулж болно.</p> <p>2. Интерактив хичээлд буй 4 тестийг бөглөх</p> <p>3. Монголын Улаан Загалмай Нийгэмлэгээс гаргасан “Анхны тусламж” нэртэй гар утасны аппликэйшнийг татан авч Анхны тусламж хэсгийн Түлэгдэлт сэдвийг уншиж судална уу.</p> <p>4. Гар утасны аппликэйшний Түлэгдэлт сэдэв дотор Модульд байхгүй ямар нэмэлт мэдээллүүд байгааг хэлэлцүүлэгт бичиж хуваалцана уу.</p> <p>5. Мөн дараах цахим хуудаст замчлалын дагуу орж, нэмэлт мэдээллүүдийг аваарай: http://gemtel.mn/ → мэдээ, мэдээлэл → зөвлөмж → түлэнхийн анхан шатны тусламж http://103.ub.gov.mn/index.php/2013-12-04-03-55-08/2013-12-05-00-38-33/116-2013-12-17-02-16-17</p>

ШАЛГАЛТ БА ҮНЭЛГЭЭ

Оролцогчдын мэдлэгийг бататгах асуултуудыг асууж, урьд хэрэглэдэг байсан анхны тусламжийн аргуудаас энэхүү арга нь яагаад илүү болохыг асуух.

Дадлага ажлын үед түлэгдэлтэй өвчтөнд үзүүлэх анхны тусламжийн 8 алхмыг бүрэн гүйцэтгэж байгаа эсэхийг ярилцах.

ХИЧЭЭЛИЙН ЦАГ

Суралцахуй	Танхимд	Онлайнаар	Нийт
Онол	Багшийн лекц (интерактив агуулгаа ашиглана) 0.5 цаг	Интерактив агуулгыг судлах, тест бөглөх 0.5 цаг	1 цаг
Дадлага	Бүлгээр, эсвэл ганцаарчилсан дадлага, даалгавар хийх 1 цаг	Хэлэлцүүлэгт оролцох, даалгавар хийх 0.5 цаг	1.5 цаг
Нийт	1.5 цаг	1 цаг	2.5 цаг

МОДУЛЬ 4

ХИМИЙН ОСЛЫН ҮЕД АНХНЫ ТУСЛАМЖ ҮЗҮҮЛЭХ

СУРГАЛТЫН ЗОРИЛГО

- Ажлын байранд химийн бодисын аюул осолд хүргэдэг аюулгүй байдлын гол эрсдлүүдийг тоочиж чаддаг болох
- Эдгээр ослоос сэргийлэх аюулгүй ажиллагааны арга хэмжээнүүдийг таниулах
- Химийн бодистой холбоотой ослын үед анхны тусламж үзүүлэх мэдлэг, чадварыг эзэмшүүлэх

ХИЧЭЭЛИЙН АГУУЛГА

Бүлэг 1. Ажлын байрны аюулгүй ажиллагаа: Химийн бодис

Бүлэг 2. Арьс химийн бодист түлэгдэх

Бүлэг 3. Залгиж хордох

Бүлэг 4. Амьсгалж хордох

Бүлэг 5. Өөрийгөө сорих тест

Танхимд дадлагажуулах сургалтанд ашиглах багаж хэрэгсэл, үзүүлэн материал

Зайлшгүй байх зүйлс	Нэмэлтээр байх зүйлс
<ul style="list-style-type: none">• Цагаан самбар, флипчарт, маркер• Манекен• Боолтын материалууд, хөнжил	<ul style="list-style-type: none">• Үйлдвэрт ашиглагддаг хортой, аюултай химийн бодисын сав• Хор аюулын лавлагаа мэдээллийн жишээ

Танхимд хичээл заахдаа интерактив сургалтын материал, видеог дэлгэцэнд харуулж байгаад тайлбарлана. Интерактив хичээлийн төгсгөлд байгаа өөрийгөө сорих 3 тестийг хамтран гүйцэтгэж, зөв буруу хариултыг ярилцана.

ХЭЛЭЛЦҮҮЛГИЙН СЭДВҮҮД

Бүлэг 1. Ажлын байрны аюулгүй ажиллагаа: Химийн бодис

- Таны ажлын байранд хэрэглэгддэг ямар химийн бодисууд байдаг вэ?
- Тэдгээр химийн бодисуудыг хэрхэн аюулгүй, зөв хэрэглэх талаар та хаанаас мэдээлэл авдаг вэ?

Бүлэг 2. Арьс химийн бодист түлэгдэх

- Арьс химийн бодист түлэгдсэн үед аюулгүй байдлыг хангаж бээлий өмсөхөөс гадна өөр ямар арга хэмжээ авч болох вэ?
- Арьснаас химийн бодисыг зайлуулахад хувцсыг тайлах, ус гоожуулахаас гадна өөр нарийвчилсан арга хэмжээ авах тухай зөв мэдээллийг хаанаас авах вэ?

Бүлэг 3. Химийн бодис залгиж хордох

- Химийн бодис залгисан үед яагаад ус уулгаж болохгүй вэ?
- Танай ажлын байранд ундны устай андуурагдаж хүн ууж болзошгүй ямар химийн бодис байгаа вэ?

Бүлэг 4. Химийн бодис амьсгалж хордох

- Танай ажлын байранд амьсгалын замаар хордуулах химийн бодис хэрэглэгддэг үү? Тийм бол ямар?
- Химийн бодис амьсгалж хордсон хүн хязгаарлагдмал орчинд ухаангүй байгаа тохиолдолд та хэнд хамгийн түрүүнд мэдээлж, ямар алхмуудыг гүйцэтгэсний дараа тэр орчинд нэвтрэх вэ?

ДААЛГАВАР

Танхимд	Онлайнаар
<p>1. Химийн бодист арьсаар, хоол боловсруулах замаар, амьсгалаар гэсэн 3 замаар өртөх ослуудын зохиомжит тохиолдууд дээр суралцагчдыг 3 бүлэгт хувааж, дасгал ажил хийлгэ. Химийн бодис ямар замаар бие махбодод нэвтэрч, хордуулж байгаагаас хамааран өөр өөр шинж тэмдэг илрэх, анхны тусламжийн арга хэмжээ мөн харилцан адилгүй байхыг сайтар ойлгуулаарай. Анхны тусламж үзүүлэхдээ нэн тэргүүнд анхаарах зүйл бол өөрийн болон ойр орчимд байгаа хүмүүсийн аюулгүй байдал гэдгийг дасгал ажлын явцад суралцагчдад сайтар анхааруулна уу.</p> <p>2. Ухаангүй боловч амьсгалтай байгаа осолдогчийг сэргээх байрлалд оруулах дадлага ажлыг суралцагч бүр гүйцэтгэж чадаж байгаа эсэхийг шалга. Сэргээх байрлалын ач холбогдлыг сайтар тайлбарлаж өгөөрэй.</p>	<p>1. Хэлэлцүүлгийн 8 асуултанд хариулах. Мөн шинээр асуулт оруулж болно.</p> <p>2. Интерактив хичээлд буй 3 тестийг бөглөх Дараах цахим хуудсаар нэвтрэн орж "ХИМИЙН ХОРТ БОЛОН АЮУЛТАЙ БОДИСЫН АНГИЛЛЫГ АШИГЛАХ АРГАЧЛАЛ"-ын 6 дугаар бүлэгт байгаа "Хор аюулын талаарх мэдээлэл" хэсгийг уншиж танилцана уу. https://www.legalinfo.mn/annex/details/6984?lawid=11509 Танай ажлын байранд хэрэглэгддэг химийн бодисуудын хор аюулын лавлах мэдээллийг багтаасан баримт бичгийн сан байдаг талаар олж мэдэх. Дараах холбоосоор орж, осолдогчийг "сэргээх байрлал"-д хэрхэн оруулах зааварчилгаа видеог үзээрэй. https://www.youtube.com/watch?v=GmqXqwSV3bo</p>

ШАЛГАЛТ БА ҮНЭЛГЭЭ

Химийн бодисын ослын үед үзүүлэх анхны тусламжийн алхам бүрийг оролцогч бүр ягштал баримтлан хийж байгаа эсэхийг танхимын сургалтын дасгал ажлын явцад шалгана.

ХИЧЭЭЛИЙН ЦАГ

Суралцахуй	Танхимд	Онлайнаар	Нийт
Онол	Багшийн лекц (интерактив агуулгаа ашиглана) 0.5 цаг	Интерактив агуулгыг судлах, тест бөглөх 0.5 цаг	1 цаг
Дадлага	Бүлгээр, эсвэл ганцаарчилсан дадлага, даалгавар хийх 1 цаг	Хэлэлцүүлэгт оролцох, даалгавар хийх 0.5 цаг	1.5 цаг
Нийт	1.5 цаг	1 цаг	2.5 цаг

МОДУЛЬ 5

БИТҮҮ БЭРТЭХ ҮЕД ҮЗҮҮЛЭХ АНХНЫ ТУСЛАМЖ

СУРГАЛТЫН ЗОРИЛГО

- Битүү бэртэх осолд хүргэдэг аюулгүй байдлын гол эрсдлүүдийг тоочиж чаддаг болох
- Эдгээр ослоос сэргийлэх аюулгүй байдлын арга хэмжээнүүдийн талаар таниулах
- Битүү бэртэж гэмтсэн үед анхны тусламж үзүүлэх мэдлэг, чадварыг эзэмшүүлэх

ХИЧЭЭЛИЙН АГУУЛГА

Бүлэг 1. Ажлын байрны аюулгүй байдал: Битүү бэртэл

Бүлэг 2. Үйлдвэрийн бодит жишээ

Бүлэг 3. Битүү бэртэх үед анхны тусламж үзүүлэх

Бүлэг 4. Өөрийгөө сорих тест

Танхимд дадлагажуулах сургалтанд ашиглах багаж хэрэгсэл, үзүүлэн материал

Зайлшгүй байх зүйлс	Нэмэлтээр байх зүйлс
<ul style="list-style-type: none"> • Төрөл бүрийн боолт, наалт, гурвалжин алчуур • Цагаан самбар, флипчарт, маркер 	<ul style="list-style-type: none"> • Чиг тавьж боох, бэхэлгээ хийх хатуу материал • Зориулалтын чиг

Танхимд хичээл заахдаа интерактив сургалтын материал, видеог дэлгэцэнд харуулж байгаад тайлбарлана. Интерактив хичээлийн төгсгөлд байгаа өөрийгөө сорих 3 тестийг хамтран гүйцэтгэж, зөв буруу хариултыг ярилцана.

ХЭЛЭЛЦҮҮЛГИЙН СЭДВҮҮД

Бүлэг 1. Ажлын байрны аюулгүй байдал: Битүү бэртэл

- Битүү бэртэл гэдэгт таны мэдэх ямар гэмтлүүд багтаж болох вэ?

Хариулт:

- Ясны хугарал
- Булчин тасрах
- Шөрмөс, холбоос тасрах, урагдах
- Дотуур цус алдах (Арьс булчингийн завсраар эсвэл биеийн аль нэг хөндийд)
- Үе мултрах
- Удаан хугацааны дарагдал гэх мэт.
- Таны ажлын байранд битүү бэртэл үүсгэж болох ямар эрсдлүүд байж болох вэ?

Бүлэг 2. Үйлдвэрийн бодит жишээ

- Үйлдвэрийн жишээн дээр: тусламж ирж ажилтанг гидравлик машинаас салгах хүртэл ямар арга хэмжээ авах хэрэгтэй вэ?
- Осолдсон ажилтанд өөр ямар төрлийн гэмтлүүд хавсарч тохиолдсон байж болох вэ? Ямар хүндрэлүүд гарч болох вэ?

Бүлэг 3. Битүү бэртэх үед анхны тусламж үзүүлэх

- Битүү бэртлийн үед хавсран гарах гэмтлүүдэд анхны тусламж үзүүлэхийн тулд ямар хэрэгслүүдийг бэлэн байлгах шаардлагатай вэ?
- Битүү бэртэлтэй өвчтөнийг дараагийн тусламж иртэл, эсвэл зөөвөрлөх хүртэл яагаад хөлийг нь өндөрлөж хэвтүүлэх хэрэгтэй вэ?

ДААЛГАВАР

Танхимд	Онлайнаар
<ol style="list-style-type: none"> Оролцогчдыг 4-5 хүнтэй бүлэгт хувааж, ажлын байранд битүү бэртэж болох өгөгдсөн 5 тохиолдлоор зохиомжит дасгал ажлуудыг хийлгэ. Бүлэг бүр дасгал ажлуудыг бодит тохиолдлын байдлаар нийт оролцогчдод жүжигчлэн танилцуулж, сэдвийн хүрээнд хэлэлцүүлэг хийх. Энэ үед анхны тусламж үзүүлэхдээ алхам бүрийг дарааллын дагуу зөв гүйцэтгэж байгаа эсэхийг сайтар шалган чиглүүлэх. 	<ol style="list-style-type: none"> Хэлэлцүүлгийн 6 асуултанд хариулах. Мөн шинээр асуулт оруулж болно. Интерактив хичээлд буй 3 тестийг бөглөх МУЗН-ийн Анхны тусламж аппликэйшний “Цохигдсон шарх болон зөөлөн эдийн гэмтэл” хэсгийг уншиж, олж авсан нэмэлт мэдээллээсээ хэлэлцүүлэгт хуваалцах.

ШАЛГАЛТ БА ҮНЭЛГЭЭ

Дадлага ажлын явцад оролцогчид битүү бэртлүүдийн төрлүүдийн талаар бүрэн дүүрэн ойлголттой байгаа эсэхийг сайтар анзаарах,

Битүү бэртлүүд нь бусад ямар гэмтлүүдтэй хавсран тохиолдож болох, ямар хүндрэлүүдийг дагуулж болох талаар оролцогчдыг ойлголтыг шалган үнэлэх.

Тэдгээр хавсарсан гэмтлүүд болон хүндрэлүүдэд тохирсон, үр дүнтэй анхны тусламж үзүүлж чадаж байгаа эсэхийг анхаар.

ХИЧЭЭЛИЙН ЦАГ

Суралцахуй	Танхимд	Онлайнаар	Нийт
Онол	Багшийн лекц (интерактив агуулгаа ашиглана) 0.5 цаг	Интерактив агуулгыг судлах, тест бөглөх 0.5 цаг	1 цаг
Дадлага	Бүлгээр, эсвэл ганцаарчилсан дадлага, даалгавар хийх 1 цаг	Хэлэлцүүлэгт оролцох, даалгавар хийх 0.5 цаг	1.5 цаг
Нийт	1.5 цаг	1 цаг	2.5 цаг

МОДУЛЬ 6

НҮД ГЭМТЭХ ҮЕД АНХНЫ ТУСЛАМЖ ҮЗҮҮЛЭХ

СУРГАЛТЫН ЗОРИЛГО

- Ажлын байранд нүдэнд гэмтэл учруулж болзошгүй аюулгүй байдлын гол эрсдлүүдийг тоочиж чаддаг болох
- Эдгээр ослоос сэргийлэх аюулгүй байдлын арга хэмжээнүүдийг таниулах
- Нүд гэмтсэн үед анхны тусламж үзүүлэх зарчим, дараалал, арга хэмжээнүүдийг ойлгуулан ур чадвар олгох

ХИЧЭЭЛИЙН АГУУЛГА

Бүлэг 1. Ажлын байрны аюулгүй байдал: Нүд гэмтэх

Бүлэг 2. Үйлдвэрийн бодит жишээ

Бүлэг 3. Нүд гэмтэх үед анхны тусламж үзүүлэх

Бүлэг 4. Өөрийгөө сорих тест

Танхимд дадлагажуулах сургалтанд ашиглах багаж хэрэгсэл, үзүүлэн материал

Зайлшгүй байх зүйлс	Нэмэлтээр байх зүйлс
<ul style="list-style-type: none">• Нүдний зориулалтын боолт• Шархны наалт, боолт• Цаасан аяга• Нүд угаах шингэн• Цагаан самбар, флипчарт, маркер	<ul style="list-style-type: none">• Нүд угаах зориулалтын сав• Нүд зайлах цэг

Танхимд хичээл заахдаа интерактив сургалтын материалыг дэлгэцэнд харуулж байгаад тайлбарлана. Интерактив хичээлийн төгсгөлд байгаа өөрийгөө сорих 3 тестийг хамтран гүйцэтгэж, зөв буруу хариултыг ярилцана.

ХЭЛЭЛЦҮҮЛГИЙН СЭДВҮҮД

Бүлэг 1. Ажлын байрны аюулгүй байдал: Нүд гэмтэх

- Таны ажлын байранд нүд гэмтээх эрсдлүүд юу байж болох вэ?
- Таны ажлын байранд хэн нэг нь нүдээ гэмтээсэн тохиолдол гарч байсан уу?

Бүлэг 2. Үйлдвэрийн бодит жишээ

- Үйлдвэрийн бодит жишээн дээр ажилтан нүдээ хүчиллэг шингэнд гэмтээснийг мэдмэгц аюулгүй байдлын үүднээс авах анхны арга хэмжээнүүд юу вэ?
- Ажилтан нүдээ гэмтээхгүй байх аюулгүй ажиллагааны ямар зааварчилгаануудыг авсан байх ёстой вэ?

Бүлэг 3. Нүд гэмтэх үед анхны тусламж үзүүлэх

- Хуурай нунтаг химийн бодис нүд, нүүрний хэсэгт асгарсан үед нүднээс зайлуулахад усаар зайлахаас өөр ямар арга хэрэглэж болох вэ?
- Нүдэнд гаднын биет шигдсэн үед анхаарах зүйл болон авах арга хэмжээ юу байж болох вэ?

ДААЛГАВАР

Танхимд	Онлайнаар
1. Оролцогчдыг 3-4 хүнтэй бүлэгт хувааж, ажлын байранд нүд гэмтэж болох тохиолдлуудаар дадлага ажлуудыг хийлгэ. 2. Дадлага ажлын явцад модуль доторх жишээнд дурьдагдаагүй эрсдлүүд, тэр үед авах анхны тусламжийн арга хэмжээнүүдийн талаар хэлэлцээрэй. Жишээ нь: хуурай нунтаг дээрээс асгарах үед, нүдэнд гадны биет зоогдсон үед гэх мэт.	1. Хэлэлцүүлгийн 6 асуултанд хариулах. Мөн шинээр асуулт оруулж болно. 2. Интерактив хичээлд буй 3 тестийг бөглөх 3. Таны ажлын байранд аюулын 1, 2А, 2В гэсэн тэмдэглэгээнүүд бүхий химийн хортой, аюултай бодис байдаг бол эдгээр нь нүдэнд ямар аюул учруулах бодис болохыг дараах цахим хуудаснаас олж мэд. https://www.legalinfo.mn/annex/details/6984?lawid=11509

ШАЛГАЛТ БА ҮНЭЛГЭЭ

Ажлын байранд тохиолдож болох нүдний гэмтлүүдийн эрсдлүүдийн талаар оролцогчид бүрэн ойлгосон эсэхийг дадлага ажлын явцад шалгах.

Нүдний гэмтлийн үед анхны тусламж үзүүлэх 8 алхмыг оролцогч бүр ойлгож хэрэгжүүлэх ур чадвар эзэмшсэн эсэхийг сайтар шалгах. Тухайлбал анхны тусламж үзүүлэх явцдаа хамгийн түрүүнд аюулгүй байдлыг үнэлээгүй, аюулгүй байдлын арга хэмжээг аваагүй бол хангалтгүй гэж үзнэ. Нүдний гэмтэлтэй өвчтнийг тайвшруулах, сэтгэлзүйн анхны тусламж үзүүлэх нь нэн чухал. Учир нь нүд гэмтсэн үед хүмүүс харааны чадвараа түр алддаг тул илүү их айж цочирддог.

ХИЧЭЭЛИЙН ЦАГ

Суралцахуй	Танхимд	Онлайнаар	Нийт
Онол	Багшийн лекц (интерактив агуулгаа ашиглана) 0.5 цаг	Интерактив агуулгыг судлах, тест бөглөх 0.5 цаг	1 цаг
Дадлага	Бүлгээр, эсвэл ганцаарчилсан дадлага, даалгавар хийх 1 цаг	Хэлэлцүүлэгт оролцох, даалгавар хийх 0.5 цаг	1.5 цаг
Нийт	1.5 цаг	1 цаг	2.5 цаг

МОДУЛЬ 7

ЦУС АЛДАХ ҮЕД АНХНЫ ТУСЛАМЖ ҮЗҮҮЛЭХ

СУРГАЛТЫН ЗОРИЛГО

- Ажлын байранд цус алдахад хүргэж болзошгүй аюулгүй байдлын эрсдлүүдийг нэрлэж чаддаг болох
- Эдгээр осол гэмтлээс сэргийлэх аюулгүй ажиллагааны арга хэмжээнүүдийн талаар ойлгуулах
- Цус ноцтой, их хэмжээгээр алдах үед анхны тусламжийг хэрхэн зөв, үр дүнтэй үзүүлэх талаар мэдлэг, ур чадвар олгох

ХИЧЭЭЛИЙН АГУУЛГА

Бүлэг 1. Ажлын байрны аюулгүй байдал: Цус ихээр алдах

Бүлэг 2. Үйлдвэрийн бодит жишээ

Бүлэг 3. Цус алдах үед анхны тусламж үзүүлэх

Бүлэг 4. Өөрийгөө сорих тест

Танхимд дадлагажуулах сургалтанд ашиглах багаж хэрэгсэл, үзүүлэн материал

Зайлшгүй байх зүйлс	Нэмэлтээр байх зүйлс
<input type="checkbox"/> Цагаан самбар, флипчарт, маркер <input type="checkbox"/> Төрөл бүрийн боолт, самбай, шархны наалт <input type="checkbox"/> Гурвалжин алчуур	<input type="checkbox"/> Хуучин, хэрэглээнээс гарсан хувцас, даавууны тасархай <input type="checkbox"/> Зориулалтын даралттай боолт <input type="checkbox"/> Чиг тавих хатуу зүйл

Танхимд хичээл заахдаа интерактив сургалтын материал, видеог дэлгэцэнд харуулж байгаад тайлбарлана. Интерактив хичээлийн төгсгөлд байгаа өөрийгөө сорих 5 тестийг хамтран гүйцэтгэж, зөв буруу хариултыг ярилцана.

ХЭЛЭЛЦҮҮЛГИЙН СЭДВҮҮД

Бүлэг 1. Ажлын байрны аюулгүй байдал: Цус ихээр алдах

- Танай ажлын байранд цус ихээр алдах гэмтэл үүсгэх аюулгүй байдлын эрсдлүүд байгаа юу?
- Танай ажлын байранд ямар нэг эрхтэн таслагдах гэмтэл учруулж болохуйц тоног төхөөрөмж байдаг уу?

Бүлэг 2. Үйлдвэрийн бодит жишээ

- Үйлдвэрийн бодит жишээн дээр цус ихээр алдсан гэмтэл тохиолдсон үед тусламжийн хайрцаг авч иртэл их хэмжээний цус алдалтыг тогтоохын тулд юу хэрэглэж болох вэ?
- Ажилтан их хэмжээний цус алдаж байх үед өөр ямар хүндрэл тохиолдож болох вэ? (Бөөлжих, толгой эргэх, муужирч унах гэх мэт)

Бүлэг 3. Цус алдах үед анхны тусламж үзүүлэх

- Цус ихээр алдаж байгаа хэсгийг боож цусыг тогтоосны дараа тухайн хэсгийг хэрхэн байрлуулах нь чухал вэ? Сойлт, бэхэлгээ хийх шаардлага бий юу? Яагаад?
- Цус ихээр алдаж, шууд даралт болон даралттай боолтонд тогтохгүй бол өөр ямар арга хэмжээ авч болох вэ?

Хариулт: Чангалуур тавих.

- *Чангалуур тавих арга нь мөчдийн аль нэг хэсгээс их хэмжээний ноцтой цус алдаж шууд даралт болон даралттай боолтод тогтохгүй байгаа үед тухайн шархны дээгүүр дор хаяад 5 см зайд тухайн мөчний цусны урсгалыг бүрэн зогсоох зорилгоор чангалж боох аргыг хэлнэ. Чангалуурыг хэт удаан тавьсан тохиолдолд мөчдийн үзүүр хэсэгт үхжил үүсэх аюултай тул үзүүр хэсгийн өнгө, мэдрэхүйг байнга хянах, чангалуурыг тодорхой хугацааны дараа (20 минутаас 1 цаг) байн байн суллах арга хэмжээг авч байх шаардлагатай.*

ДААЛГАВАР

Танхимд	Онлайн
<ol style="list-style-type: none"> Оролцогчдыг 3-4 хүнтэй бүлэгт хувааж, ажлын байранд цус ихээр алдах гэмтлийн тохиолдлууд дээр дадлага ажлуудыг хийлгэ. Ингэхдээ биеийн өөр өөр хэсгүүдэд гэмтэл учирсан байхаар хуваарилаарай. Бүлгийн ажлын үед оролцогчид цус тогтоох арга хэмжээний алхмуудыг зөв гүйцэтгэж чадаж байгаа эсэх дээр хяналт тавиарай. Энгийн болон даралттай боолтыг уян боолт, шархны наалт, самбай, гурвалжин алчуураас гадна үйлдвэрийн орчинд байж болох гарын доорх хэрэгслийг хэрхэн ашиглаж үр дүнтэй цус тогтоох боолт хийж болох талаар зөвлөгөө өгч чиглүүл. Цус ихээр алдаж байгаа өвчтөнд гарах хүндрэлүүд (дотор эвгүйрч бөөлжих, муужрах, шоконд орох, амьсгал зогсох гэх мэт)-ийн талаар сайтар ойлгуулж ямар арга хэмжээ авахад бэлэн байх талаар сайтар ярилцаарай. 	<ol style="list-style-type: none"> Хэлэлцүүлгийн 6 асуултанд хариулах. Мөн шинээр асуулт оруулж болно. Интерактив хичээлд буй 5 тестийг бөглөх <p>Цус алдах үед модульд заасан аргаар анхны тусламж үзүүлсэн ч цус тогтохгүй бол өөр ямар арга хэрэглэж болох талаар www.gemtel.mn → зөвлөгөө → гадуур цус алдалтыг зогсоох арга хуудсаас олж мэдээд хэлэлцүүлэгт хуваалцах.</p>

ШАЛГАЛТ БА ҮНЭЛГЭЭ

Их хэмжээний цус алдалтын үед анхны тусламж үзүүлэх алхмуудыг оролцогчид бүрэн гүйцэтгэж чадаж байгаа эсэхийг бүлгийн ажлын явцад шалга.

Оролцогч бүр зориулалтын болон гарын доорх хэрэгсэл ашиглан цус тогтоох энгийн болон даралттай боолд хийж чадаж байгаа эсэхийг шалгах. Дадлага ажлын явцад оролцож байгаа байдлаар оролцогчдыг үнэлнэ.

ХИЧЭЭЛИЙН ЦАГ

Суралцахуй	Танхимд	Онлайнаар	Нийт
Онол	Багшийн лекц (интерактив агуулгаа ашиглана) 1 цаг	Интерактив агуулгыг судлах, тест бөглөх 0.5 цаг	1.5 цаг
Дадлага	Бүлгээр, эсвэл ганцаарчилсан дадлага, даалгавар хийх 1 цаг	Хэлэлцүүлэгт оролцох, даалгавар хийх 0.5 цаг	1.5 цаг
Нийт	2 цаг	1 цаг	3 цаг

МОДУЛЬ 8

ЦАХИЛГААНЫ ОСЛЫН ҮЕД ҮЗҮҮЛЭХ
АНХНЫ ТУСЛАМЖ

СУРГАЛТЫН ЗОРИЛГО

- Ажлын байранд цахилгааны осолд хүргэдэг аюулгүй байдлын гол эрсдлүүдийг тоочиж чаддаг болох
- Ажлын байранд цахилгааны ослоос урьдчилан сэргийлэх аюулгүй ажиллагааны арга хэмжээнүүдийг таниулах
- Цахилгааны ослын үед анхны тусламж үзүүлэх мэдлэг ойлголт, ур чадвар эзэмшүүлэх.

ХИЧЭЭЛИЙН АГУУЛГА

Бүлэг 1. Ажлын байрны аюулгүй байдал: Цахилгааны осол

Бүлэг 2. Үйлдвэрийн бодит жишээ

Бүлэг 3. Цахилгааны ослын үед анхны тусламж үзүүлэх

Бүлэг 4. Өөрийгөө сорих тест

Танхимд дадлагажуулах сургалтанд ашиглах багаж хэрэгсэл, үзүүлэн материал

Зайлшгүй байх зүйлс	Нэмэлтээр байх зүйлс
<ul style="list-style-type: none"> • Цагаан самбар, флипчарт, маркер • Манекен, хиймэл амьсгал хийхэд хэрэглэх ам болон нүүрний хаалт • Сургалтад зориулсан автомат дефибриллятор • Боолтын хэрэгслүүд 	<ul style="list-style-type: none"> • Зүрхний анатоми, физиологийн үйл ажиллагааг харуулсан үзүүлэнгийн самбар • Ахуйн болон, ажлын байранд хэрэглэгддэг цахилгаан хэрэгслийн утас, эвдэрхий унтраалга, залгуур гэх мэт зүйлс • Түлэгдэлт, цус алдалтын үед анхны тусламж үзүүлэхэд хэрэглэгддэг зүйлс

Танхимд хичээл заахдаа интерактив сургалтын материал, видеог дэлгэцэнд харуулж байгаад тайлбарлана. Интерактив хичээлийн төгсгөлд байгаа өөрийгөө сорих 3 тестийг хамтран гүйцэтгэж, зөв буруу хариултыг ярилцана.

ХЭЛЭЛЦҮҮЛГИЙН СЭДВҮҮД

Бүлэг 1. Ажлын байрны аюулгүй байдал: Цахилгааны осол

- Танай ажлын байранд болон гэрт цахилгааны осол үүсгэх эрсдэл бүхий тоног төхөөрөмж, цахилгааны ил утас гэх мэт зүйлс байдаг уу?
- Ажлын байранд цахилгаан тоног төхөөрөмжийн гэмтлээс үүдэлтэй саатал тохиолдох үед та өөрөө засах гэж оролдож байсан тохиолдол бий юу?

Бүлэг 2. Үйлдвэрийн бодит жишээ

- Үйлдвэрийн бодит жишээн дээр ажилтан тоног төхөөрөмж ажиллахаа болих үед цахилгааны осолд өртөлгүйгээр шалгах боломж юу байсан бэ?
- Танай ажлын байранд цахилгаан тоног төхөөрөмжтэй ажиллах үеийн аюулгүй ажиллагааны зааварчилгаа байдаг уу?

Бүлэг 3. Цахилгааны ослын үед анхны тусламж үзүүлэх

- Цахилгааны осолд өртөж ухаангүй байгаа хүнд дөхөж очихын өмнө орчны болон өөрийн аюулгүй байдлаа хангах үүднээс зөвхөн тухайн тоног төхөөрөмжийг цахилгаанаас салгах нь хангалттай юу? Яагаад?
- Ухаангүй байгаа осолдогчийг цахилгааны осолд өртсөнийг мэдэж байгаа бол дараагийн тусламж болох зүрх уушгины сэхээн амьдруулалт хийхийн тулд ямар гадарга дээр байрлуулах ёстой вэ?

ДААЛГАВАР

Танхимд	Онлайнаар
<ol style="list-style-type: none"> Оролцогчдыг 3-4 хүнтэй бүлэгт хувааж, ажлын байранд цахилгааны осолд өртөж байгаа тохиолдлуудыг өөрсдөөр нь зохиолгон, дадлага ажил хийлгэ. Аюулгүй байдлын үүднээс цахилгааны осол гарсан хэсэгт цахилгааны бүрэн таслах ослын унтраалгыг ашиглах ёстой гэдгийг дадлага ажлын явцад ойлгуулах. Ажлын байранд ийм ослын унтраалгын байрлалыг ажилтан бүр мэддэг байх ёстой. Цахилгааны ослын үед ухаангүй болох, зүрх зогсохоос өөр ямар төрлийн гэмтлүүд тохиолдож болох талаар ярилцах. (Жишээ нь: түлэгдэх) Автомат дефибрилляторын ажиллах зарчмыг сайтар ойлгуулсны дараа ажиллуулах зааврыг тайлбарлах. Ухаангүй хүнийг үнэлэх, зүрх уушгины сэхээн амьдруулалт (ЗУСА) буюу цээжний даралт, хиймэл амьсгалын дадлагыг дахин оролцогч бүрээр хийлгэх. 	<ol style="list-style-type: none"> Хэлэлцүүлгийн 6 асуултанд хариулах. Мөн шинээр асуулт оруулж болно. Интерактив хичээлд буй 3 тестийг бөглөх Дараах цахим хуудсаар нэвтрэн орж автомат дефибрилляторыг хэрхэн ашиглах талаар видео танилцуулгыг анхааралтай үзнэ үү. Автомат дефибрилляторыг ашиглах талаар асуулт гарган хэлэлцүүлэгт оруулна уу.

ШАЛГАЛТ БА ҮНЭЛГЭЭ

Дадлага ажлын явцад оролцогчид цахилгааны ослын үед анхны тусламж үзүүлэх дарааллуудыг ягштал гүйцэтгэж байгаа эсэхийг үнэлэх. Ялангуяа аюулгүй байдлыг хүн бүр шалгаж, аюулгүй ажиллагааг мөрдөж байгаа эсэх.

ХИЧЭЭЛИЙН ЦАГ

Суралцахуй	Танхимд	Онлайнаар	Нийт
Онол	Багшийн лекц (интерактив агуулгаа ашиглана) 1 цаг	Интерактив агуулгыг судлах, тест бөглөх 0.5 цаг	1.5 цаг
Дадлага	Бүлгээр, эсвэл ганцаарчилсан дадлага, даалгавар хийх 1 цаг	Хэлэлцүүлэгт оролцох, даалгавар хийх 0.5 цаг	1.5 цаг
Нийт	2 цаг	1 цаг	3 цаг


4

ЦАХИМ ТАЛБАР ДАХЬ БАГШИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

“Ажлын байранд анхны тусламж үзүүлэх нь” цахим хичээл нь НҮБАҮХБ-ын цахим сургалтын талбарт байршсан байгаа ба энэ нь сургалт удирдах, нээлттэй эх бүхий Moodle систем дээр хийгдсэн юм. Moodle системд багш хэрхэн ажиллах зааварчилгааг https://docs.moodle.org/32/en/Teacher_quick_guide хаягаар орж англи хэлээр дэлгэрүүлэн үзэх боломжтой.

4.1 НУУЦ ҮГЭЭ СЭРГЭЭХ

Хэрэв багш, суралцагч цахим талбарт нэвтрэх нууц үгээ мартсан бол цахим талбарын нүүр хуудсанд **Lost password** холбоосыг дарна:



The screenshot shows the UNIDO Capacity Development E-Learning Platform interface. The page title is "UNIDO Capacity Development: E-Learning Platform". The URL is "https://capacitydevelopment.unido.org/moodle/". The page is in English (EN). The user is not logged in. The page features a search bar, a list of courses, and a login form. A green arrow points to the "Lost password?" link in the login form.

UNIDO Capacity Development: E-Learning Platform

Search courses Go

Courses

- Leather and Textiles - PTC/AGR/AIT
 - Mongolia - Монгол улс
 - Арьс ширний ээлтэй үйлдвэрлэл
 - Ажлын байранд анхны тусламж үзүүлэх нь
 - Хүэрт үстөрөгчийн хийтэй хэрхэн харьцах вэ?

LOGIN

Username / email

Password

Remember username

[Create new account](#)

[Lost password?](#)

Цахим талбарт бүртгүүлсэн Хэрэглэгчийн нэр, эсвэл имэйл хаягаа бичээд **Search** товчлуур дарна:

UNIDO Capacity Development: E-Learning Platform

[Home](#) / [Log In](#) / [Forgotten password](#)

To reset your password, submit your username or your email address below. If we can find you in the database, an email will be sent to your email address, with instructions how to get access again.

Search by username

Username

1. Бүртгүүлсэн нэрээ бичнэ

2

Search by email address

Email address

Бүртгүүлсэн имэйл хаягаа бичиж хайж болно

Хэрэв таны оруулсан мэдээлэл үнэн зөв бол таны бүртгэлтэй имэйл хаягаар нууц үг сэргээх холбоосыг илгээснээ мэдэгдэнэ:


UNIDO Capacity Development: E-Learning Platform

[Home](#) / [Log In](#) / [Forgotten password](#)

If you supplied a correct username or email address then an email should have been sent to you.

It contains easy instructions to confirm and complete this password change. If you continue to have difficulty, please contact the site administrator.

Та талбарт бүртгүүлсэн имэйл хаягаа шалгаарай. Нууц үг сэргээх имэйл тэр даруй ирсэн байх ба хүсэлт илгээснээс хойш 30 минутын дотор холбоосыг дарах хэрэгтэй:

 Tue 4/30/2019 1:24 PM

Franz Brugger (via UNIDO Capacity Development) <noreply@unido.org>

UNIDO Capacity Development: E-Learning Platform: Password reset request

To: YADAMSUREN, Tsetseg-Ulzii

Retention Policy Delete Inbox after 1 year (1 year) Expires 5/14/2020

i We removed extra line breaks from this message.

Hi Test,

A password reset was requested for your account 'test' at UNIDO Capacity Development: E-Learning Platform.

To confirm this request, and set a new password for your account, please go to the following web address:

https://capacitydevelopment.unido.org/moodle/login/forgot_password.php?token=m3MpG8ZAUancZJKrA6SE89HZyNca8CG
(This link is valid for 30 minutes from the time this reset was first requested)

If this password reset was not requested by you, no action is needed.

If you need help, please contact the site administrator,


Холбоосыг дарна

Franz Brugger
f.brugger@unido.org

Холбоосыг дарснаар цахим талбарт дараах хуудсанд очих ба шинэ нууц үгээ 2 удаа бичиж, **Save changes** дарснаар та шинэ нууц үгтэй болно. Шинэ нууц үгээ тэмдэглэж авахаа мартаузай:

4.2 ПРОФАЙЛДАА ЗУРАГ, МЭДЭЭЛЭЛ ОРУУЛАХ

Багш, суралцагчид цахим талбарт профайлдаа зураг оруулахын тулд баруун дээд булан дахь нэр дээрээ дарж, унадаг цэснээс **Profile** гэж сонгоно. Гарч ирэх хуудсанд **Edit Profile** холбоос дарна:



Description цонхонд өөрийн тухай танилцуулж бичнэ. **Expand all** холбоосыг дарж мэдээлэл оруулах бүх хэсгийг дэлгэнэ.

Test Mongolia

[Expand all](#)

▼ **General**

First name *

Surname *

Email address *

Email display

City/town

Select a country

Timezone

Description ?

Багш, суралцагчид өөрийн танилцуулгыг энд бичнэ.

▼ **User picture**

Цээж зургаа урьдчилэн бэлтгэсэн байх ба дараах цонхонд чирж тавина. Өөрийн сонирхол болон социал хаягуудаа хүсвэл оруулаад **Update profile** товчлуурыг дарна. Та цахим талбарт профайлын зураг, мэдээллээ хэдэн ч удаа өөрчилж болно.

▼ **User picture**

Current picture None

New picture ? Maximum size for new files: 50MB, maximum attachments: 1

Files

You can drag and drop files here to add them.

Picture description

▶ **Additional names**

▼ **Interests**

List of interests ? No selection

▶ **Optional**


[Update profile](#)

There are required fields in this form marked *.


Профайлын
зургаа энд
орчуулна

4.3 ХЭЛЭЛЦҮҮЛЭГТ БИЧИХ

Багш хэлэлцүүлэгт шинэ хэлхээ үүсгэхийн тулд хичээлийн талбараас Хэлэлцүүлэгт ороод **Add a new discussion topic** товчийг дарна:




Subject цонхонд хэлэлцүүлгийн нэр буюу гарчгийг бичнэ. Гарчиг нь маш товч, асуулт хэлбэртэй байвал суралцагчдад хариулах сэдэл идэвх төрүүлнэ. **Message** цонхонд хэлэлцүүлгийн их бие буюу асуултаа тайлбарын хамт дэлгэрүүлж бичнэ. Хэлэлцүүлэгт баримт бичиг, үзүүлэн слайд, зураг зэрэг файл хавсаргаж болно. Эцэст нь **Post to forum** товчлуурыг дарж, хэлэлцүүлгээ нийтэлнэ:



4.4 ДААЛГАВАРТ ЗӨВЛӨМЖ ХАРИУ ӨГӨХ

Багш суралцагчийн даалгавар бүрд зөвлөмж хариу өгөх нь сургалтын үр дүнд чухал хувь нэмэртэй билээ. Суралцагчдын оруулсан даалгавруудыг харах, хариу өгөхийн тулд хичээлийн талбараас тухайн **Даалгавар** руу орно:

Модуль 1. Анхны тусламжийн хайрцаг


 **Судлах агуулга ба тест: Анхны тусламжийн иж бүрдэл**


Энэхүү цахим хичээлээр арьс шир, гутлын үйлдвэрүүдийн ажлын байран дахь анхны тусламжийн иж бүрдэлд зайлшгүй агуулагдах шаардлагатай зүйлсийг судлах болно.


Суралцагчид нь дараах ойлголт мэдлэгийг олж авна. Үүнд:


- Анхны тусламжийн иж бүрдэлд зайлшгүй байх зүйлс
- Анхны тусламжийн иж бүрдэлд агуулагдах зүйлсийг хэрхэн зөв хэрэглэх


Доорх **Enter** товчийг дарж хичээлдээ орно уу.

 [Хэлэлцүүлэг - Модуль 1](#)

 [Даалгавар 1 - Анхны тусламжийн хайрцагт байвал зохих зүйлс](#)

 [Даалгавар 2 - Ажил үүргийн жагсаалт](#)

 [Даалгавар 3 - Анхны тусламжийн хайрцаг байршуулах төлөвлөгөө](#)




Энд даалгавраа оруулсан суралцагчийн тоо, үнэлүүлэхээр хүлээж буй даалгарын тоо харагдана. **View all submissions** холбоосыг дарна:

Даалгавар 1 - Анхны тусламжийн хайрцагт байвал зохих зүйлс

Байгууллагынхаа анхны тусламжийн хайрцагт байвал зохих зүйлсийг өгсөн хүснэгтэд гаргаж ашиглана уу.


Даалгаврын файлаа өөрийн нэрээр нэрлээд Add submissions товч даран, энд буцааж оруулаарай.

Багш нь

 [FA M1-Daalgavar1.docx](#)

Grading summary

Participants	12
Submitted	1
Needs grading	1


[View all submissions](#) [Grade](#)

Тухайн суралцагчийн оруулсан даалгаврыг татаж авч үзсэний дараа **Grade** товчлуурыг дарж орно:

Даалгавар 1 - Анхны тусламжийн хайрцагт байвал зохих зүйлс

Grading action: Choose...

First name: All A B C D E F G H I J K L M N O P Q R S T U V W X Y Z
Surname: All A B C D E F G H I J K L M N O P Q R S T U V W X Y Z

Select	User picture	First name / Surname	Email address	Status	Grade	Edit	Last modified (submission)	File submissions	Submission comments	Last modified (grade)	Feedback comments	Final grade
<input type="checkbox"/>		Ivan Kral	ikral@unido.org	No submission	Grade	Edit						
<input type="checkbox"/>		Vishwanathan Murusamy	mviswanathan@outlook.com	No submission	Grade	Edit						
<input type="checkbox"/>		Sebastian Hochwallner	s.hochwallner@unido.org	No submission	Grade	Edit						
<input type="checkbox"/>		Munkhbolor Gungaa	bolor3995@gmail.com	No submission	Grade	Edit						
<input type="checkbox"/>		Tsetseg-Ulzil Yadamsuren	tsetseg@gmail.com	Submitted for grading	Grade	Edit	Monday, 29 April 2019, 6:58 AM	FA M1 - Daaljavari - Tsetseg.docx	Comments (0)			
<input type="checkbox"/>		TestMN MN	tsetseg_ulzil@hotmail.com	No submission	Grade	Edit						

Grade цонхонд даалгаврын оноог, **Feedback comments** цонхонд зөвлөмж хариугаа бичээд **Save changes** товч дарж хадгална. **Notify students** сонголтыг идэвхжүүлснээр даалгаврын хариуг талбарт оруулсан тухай мэдэгдэл суралцагчид имэйлээр очно:

Course: Ажлын байранд анхны тусламж үзүүлэх нь
Assignment: Даалгавар 1 - Анхны тусламжийн хайрцагт ба...

Tsetseg-Ulzil Yadamsuren
tsetseg@gmail.com

11 of 12

Submission
Submitted for grading
Not graded
Student can edit this submission
FA M1 - Daaljavari - Tsetseg.docx
Comments (0)



Grade
Grade out of 100
95
Current grade in gradebook

Feedback comments
Багш зөвлөмж хариугаа энд бичнэ.

Notify students **Save changes** Reset

4.5 ЦАХИМ ТАЛБАРТ СУРАЛЦАГЧДЫН ЯВЦЫГ ХАРАХ

Багш хичээлийн талбарт орж, зурагт үзүүлсэн дарааллын дагуу тайланг гаргаж авна. Үүнд:



4.5.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Энэхүү тайланд хичээлийн агуулга бүрийг хэдэн оролцогч (багшийг оролцуулаад) хичнээн удаа үзсэн, аль агуулгыг хамгийн бага /хамгийн их үзсэн, хамгийн сүүлийн хандалт хэзээ байсныг харуулна. Уг тайланг 7, 14, 30 хоногийн давтамжтай хадгалж аваад сургалтын явцыг ажиглах боломжтой.

The screenshot shows a Moodle activity report for 'First Aid MN'. The page title is 'Ажлын байранд анхны тусламж үзүүлэх нь'. The report is computed from logs since Friday, 9 December 2011, 3:05 PM. It displays a table of activities with columns for Activity, Views, and Last access. The activities are grouped into two modules: 'Модуль 1. Анхны тусламжийн хайрцаг' and 'Модуль 2. Зүрхний шигдээсийн үед анхны тусламж үзүүлэх'.

Activity	Views	Last access
Силлабус	14 by 4 users	Monday, 22 April 2019, 9:36 AM (8 days 18 hours)
Зар мэдээлэл	13 by 5 users	Thursday, 23 April 2019, 5:24 PM (3 days 11 hours)
Ерөнхий хэлэлцүүлэг	7 by 3 users	Monday, 22 April 2019, 9:35 AM (8 days 18 hours)
Хөөрөлдөх өрөө	5 by 3 users	Monday, 22 April 2019, 9:35 AM (8 days 18 hours)
Модуль 1. Анхны тусламжийн хайрцаг		
Судлах агуулга ба тест: Анхны тусламжийн иж бүрдэл	61 by 5 users	Friday, 19 April 2019, 3:05 AM (10 days 1 hour)
Хэлэлцүүлэг - Модуль 1	2 by 1 users	Monday, 22 April 2019, 9:28 AM (8 days 18 hours)
Даалгавар 1 - Анхны тусламжийн хайрцагт байвал зохих зүйлс	5 by 1 users	Tuesday, 23 April 2019, 5:24 AM (8 days 23 hours)
Даалгавар 2 - Анхны тусламжийн хайрцагт байршуулах төлөвлөгөө	5 by 1 users	Tuesday, 23 April 2019, 5:26 AM (8 days 22 hours)
Даалгавар 3 - Анхны тусламжийн хайрцагт байршуулах төлөвлөгөө	1 by 1 users	Tuesday, 23 April 2019, 5:27 AM (8 days 22 hours)
Модуль 2. Зүрхний шигдээсийн үед анхны тусламж үзүүлэх		
Судлах агуулга ба тест: Зүрхний шигдээс	57 by 5 users	Friday, 19 April 2019, 2:35 AM (10 days 1 hour)
Хэлэлцүүлэг - Модуль 2	-	-
Даалгавар - Зүүн амьдралын хэв маяг	17 by 1 users	Tuesday, 23 April 2019, 5:27 AM (8 days 22 hours)


Тайланг хадгалж авахын тулд screenshot буюу дэлгэцийн зураг авч, файлын нэрд огноогоо оруулан хадгалж болно. Түүнчлэн PDF файлаар хадгалж авах боломжтой. Үүний тулд:

1. Тухайн хуудсанд байхдаа Ctrl + P дарна.
2. Destination-ыг Save as PDF гэж сонгоод Save дарна:


The screenshot shows the print dialog box in a browser. The print settings are: Total: 2 sheets of paper, Destination: Canon IR2004/2204, Pages: All, Copies: 1, Layout: Portrait. The print button is highlighted in blue. The background shows the same Moodle activity report as in the previous screenshot.

4.5.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Энэхүү тайлангаас суралцагч нэг бүрийг суралцахуйн үйл ажиллагаа бүрийг гүйцэтгэж дуусгасан эсэхийг автоматаар харна. Суралцагчийн овог, нэрийн эхний үсгийг дээр байгаа үсгийн жагсаалтаас шууд дарж гаргаж болно:



Тайланг .csv форматаар татаж аваад, .xls болгон хадгалж, боловсруулалт, дүн шинжилгээ хийж болно:



Үйл ажиллагааны гүйцэтгэлийн тайланг өмнөх тайлангийн нэг адил дэлгэцийн зургаар, эсвэл PDF болгон хадгалж авах боломжтой юм.

4.5.3 СУРАЛЦАГЧИЙН ЛОГ БҮРТГЭЛ

Суралцагчийн лог бүртгэлээс түүнийг хэзээ, ямар давтамжтайгаар цахим талбарт нэвтэрсэн, юу хийсэн, хичнээн click буюу үйлдэл хийснийг харж болно. Цаашлаад ямар IP хаягаас, ямар төхөөрөмж (гар утас эсвэл компьютер) ашиглан ажилласныг ч харах боломжтой. Лог бүртгэл нь суралцагчийн бүтээлч ажиллагаа, зарцуулсан цагийг үнэлэх, суралцагчдын үйл ажиллагааг хооронд нь харьцуулан үнэлэхэд чухал ач холбогдолтой юм.

Лог бүртгэлийг үзэхийн тулд хичээлийн талбарын зүүн баганад **Participants**, гарч ирсэн нэрсээс тухайн суралцагчийн нэрийг дарж орно:

The screenshot shows the Moodle interface for the 'First Aid MN' course. The 'Participants' menu item in the left sidebar is highlighted with a green arrow labeled '1'. The main content area displays a table of participants with the following data:


Select	User picture	First name / Surname	Email address	City/town	Country	Last access to course
<input type="checkbox"/>		Tsetseg-Ulzii Yadamsuren	tsetseg@gmail.com	UB	Mongolia	15 secs
<input type="checkbox"/>		Magsarjav Boldbaatar	regjinkhuu@gmail.com	Ulaanbaatar	Mongolia	3 days 16 hours
<input type="checkbox"/>		Sebastian Hochwallner	s.hochwallner@unido.org	Vienna	Austria	5 days 23 hours
<input type="checkbox"/>		Viswanathan Munusamy	mviswanathan@outlook.com	Kanpur	India	11 days 3 hours
<input type="checkbox"/>		Цорбадрах Сүхбаатар	tsogbadraks@gmail.com	Darkhan-Uul	Mongolia	11 days 3 hours
<input type="checkbox"/>		Gantulga Batbyamba	gantulga.b@redcross.mn	Ulaanbaatar	Mongolia	24 days 9 hours
<input type="checkbox"/>		Ariuntuul D	ariun_ati@yahoo.com	Darkhan	Mongolia	31 days 1 hour

Суралцагчийн профайл хуудас гарч ирэх ба **Тайлан** хэсэгт **All logs** дарж орно:

The screenshot shows the user profile page for Tsetseg-Ulzii Yadamsuren. The 'Reports' section contains the following links:

- Today's logs
- All logs
- Outline report
- Complete report
- Brower sessions
- Grades overview
- Grade

Суралцагчийн лог бүртгэл графикаар гарч ирнэ. Босоо тэнхлэгт талбарт хийсэн үйлдлийн тоог харуулж байна:



Графикийн доорх **Show chart data** дарвал өгөгдлийг дараах байдлаар жагсааж харуулах ба энэ нь суралцагчдын үйлдлийг харьцуулахад тустай байдаг:

Time	User full name	Affected user	Event context	Component	Event name	Description	Origin	IP address
29 Apr. 09:36	Tsetseg-Ulzii Yadamsuren	Tsetseg-Ulzii Yadamsuren	Course: Ажлын байранд анхны тусламж үзүүлэх нь	System	User profile viewed	The user with id '2005' viewed the profile for the user with id '2005' in the course with id '27'.	web	202.179.27.16
29 Apr. 09:36	Tsetseg-Ulzii Yadamsuren	-	Course: Ажлын байранд анхны тусламж үзүүлэх нь	System	User list viewed	The user with id '2005' viewed the list of users in the course with id '27'.	web	202.179.27.16
29 Apr. 09:34	Tsetseg-Ulzii Yadamsuren	-	Course: Ажлын байранд анхны тусламж үзүүлэх нь	System	Course viewed	The user with id '2005' viewed the course with id '27'.	web	202.179.27.16
29 Apr. 09:32	Tsetseg-Ulzii Yadamsuren	Gantulga Battuyamba	Course: Ажлын байранд анхны тусламж үзүүлэх нь	System	User profile viewed	The user with id '2005' viewed the profile for the user with id '2239' in the course with id '27'.	web	202.179.27.16
29 Apr.	Tsetseg-Ulzii Yadamsuren	-	Course: Ажлын байранд анхны тусламж үзүүлэх нь	System	User list viewed	The user with id '2005' viewed the list of users in the course with id '27'.	web	202.179.27.16

Түүнчлэн суралцагч цахим талбарт ажилласан өдөр, цаг минут, хийсэн үйлдлийн жагсаалтыг дээрх тайлангаас харж болно.

4.6 СУРАЛЦАГЧДАД ЗУРВАС ИЛГЭЭХ

Цахим талбарт багш суралцагчдадаа зурвас илгээж болох ба энэ нь суралцагчийн имэйлээр очно. Эсвэл суралцагч талбартаа нэвтрэх үедээ үзэж ч болно. Зурвас нь харилцааны нэг чухал хэрэгсэл тул суралцагчид даалгаврын хугацааг сануулах, идэвхжүүлэх зорилгоор ашиглана. Зурвасыг суралцагчид ганцаарчлан, эсвэл хэд хэдэн суралцагчид илгээх боломжтой.

Зурвас илгээхийн тулд хичээлийн талбарын зүүн баганад **Participants** дарж ороод хэрэглэгчдийн жагсаалтаас тухайн нэг, эсвэл хэдэн суралцагчийг дараах зурагт үзүүлсний дагуу сонгож тэмдэглэнэ. Жагсаалтын доорх **Choose** цэсийг дарж, **Send a message** сонгоно:

The screenshot shows the Moodle interface for a course titled "First Aid MN". The left sidebar contains a menu with "Participants" highlighted by a red arrow and the number 1. The main content area is titled "Participants" and shows a list of 12 participants. The list has columns for "Select", "User picture", "First name / Surname", "Email address", "City/town", "Country", and "Last access to course". Several rows have their "Select" checkboxes checked, with a red circle and the number 2 highlighting one of them. At the bottom of the list, there are buttons for "Select all", "Deselect all", and "With selected users...". A dropdown menu is open from the "With selected users..." button, showing options: "Choose...", "Choose...", "Send a message", "Add a new note", and "Add a common note". Red arrows and numbers 3 and 4 point to the "Choose..." and "Send a message" options respectively.

Select	User picture	First name / Surname	Email address	City/town	Country	Last access to course
<input type="checkbox"/>		Tsetseg-Ulzi Yadamsuren	tsetseg@gmail.com	UB	Mongolia	1 sec
<input type="checkbox"/>		Test Mongolia	tyadamsuren@unido.org	UB	Mongolia	24 mins 25 secs
<input type="checkbox"/>		TestMN MN	tsetseg_ulzi@hotmail.com	UB	Mongolia	3 hours 27 mins
<input checked="" type="checkbox"/>		Gantulga Batybamba	gantulga.b@redcross.mn	Ulaanbaatar	Mongolia	21 hours 30 mins
<input checked="" type="checkbox"/>		Magsarjav Boldbaatar	reginkhuu@gmail.com	Ulaanbaatar	Mongolia	4 days 14 hours
<input type="checkbox"/>		Sebastian Hochwallner	s.hochwallner@unido.org	Vienna	Austria	6 days 21 hours
<input type="checkbox"/>		Viswanathan Munusamy	mviswanathan@outlook.com	Kanpur	India	12 days 1 hour
<input checked="" type="checkbox"/>		Цорбадрах Сухбаатар	tsogbadrah@gmail.com	Darkhan-Uul	Mongolia	12 days 2 hours
<input type="checkbox"/>		Ariuntuul D	ariun_at@yahoo.com	Darkhan	Mongolia	31 days 23 hours
<input type="checkbox"/>		Ivan Král	i.kral@unido.org	Vienna	Austria	83 days 23 hours
<input type="checkbox"/>		Odontuya Tsetsegdelger	o.tsetsegdelger@unido.org	ulaanbaatar 14253	Mongolia	215 days 23 hours
<input type="checkbox"/>		Munkhbolor Gungaa	bolor3095@gmail.com	Ulaanbaatar	Mongolia	Never

Message body цонхонд зурвасаа бичээд **Send message** товчлуур дарж илгээнэ:

Message course users

[Home](#) / [My courses](#) / [First Aid MN](#) / [Participants](#) / [Message course users](#)

Added 3 new recipients

[Keep searching](#), or use the form below to send a message to the selected students

Message body:

📅 A1 ▾ **B** *I* ☰ ☰ 🔗 🔗 🖼️

Өдрийн мэнд,
 6-р модулийн хэлэлцүүлэгтээ идэвхтэй оролцоорой.
 Багш нь|

Formatting: HTML format

➔

Currently selected users

Magsarjav Boldbaatar regjinkhuu@gmail.com	<input type="button" value="Remove"/>
Цогбадрах Сүхбаатар tsogbadrakhs@gmail.com	<input type="button" value="Remove"/>
Gantulga Batbyamba gantulga.b@redcross.mn	<input type="button" value="Remove"/>

Танд амжилт хүсье!

ЦАХИМ ХИЧЭЭЛИЙН АГУУЛГААС



ХИМИЙН БОДИСЫН АЮУЛ, ОСЛЫН ҮЕД ҮЗҮҮЛЭХ АНХНЫ ТУСЛАМЖ

БҮЛГҮҮД

АЖЛЫН БАЙРНЫ АЮУЛГҮЙ
БАЙДАЛ: ХИМИЙН БОДИС

АРЬС ХИМИЙН
БОДИСТ ТҮЛЭГДЭХ

ЗАЛГИЖ ХОРДОХ

АМЬСГАЛЖ ХОРДОХ

ӨӨРИЙГӨӨ
СОРИХ ТЕСТ



Цэс



ТҮЛЭГДЭЛТИЙН ҮЕД ҮЗҮҮЛЭХ АНХНЫ ТУСЛАМЖ

Энэхүү цахим хичээлээр арьс шир, гутлын үйлдвэрт тохиолдож болох түлэгдэлттэй холбоотой аюул, ослын талаар авч үзнэ.


Энэ хичээлийг судалснаар суралцагчид дараах мэдлэгийг олж авна. Үүнд:

- Түлэгдэх аюулд хүргэдэг аюулгүй ажиллагааны гол эрсдлүүд
- Түлэгдэх аюулаас урьдчилан сэргийлэх аюулгүй ажиллагааны арга хэмжээ
- Түлэгдэлтийн үед үзүүлэх анхны тусламж






Цэс




Анхны тусламж үзүүлэх

5. Цээж дарах иллэг ба хиймэл амьсгал


Цээж дарах иллэг ба хиймэл амьсгалыг CPR гэж нэрлэх ба эдгээрийг хамтад нь хийнэ. Тус бүр дээр **дарж** нэг бүрчлэн үзээд, дараа нь хамтад нь хийхийг хараарай.



Цээж дарах иллэг



Хиймэл амьсгал



Цээж дарах иллэг ба хиймэл амьсгал (CPR)

◀
▶

Цэс



Өөрийгөө сорих тест ?

Өөрийгөө сорих тест

Хамт ажиллагч тань машинд хавчуулагдан осолдож, битүү бэртжээ. Түүнд үзүүлэх анхны тусламжийн алхмуудыг зөв дараалалд оруулна уу.

1

Гэмтсэн хүнийг чөлөөлнө.

2

Шархыг бооно.

3

Машиныг унтрааж, бээлий өмсөнө.

4

Эмнэлгийн тусламж авна

◀
ИЛГЭЭХ
▶



МОНГОЛЫН
УЛААН ЗАГАЛМАЙ
НИЙГЭМЛЭГ



14210 Улаанбаатар хот,
Сүхбаатар дүүрэг, Энхтайвны гудамж



info@redcross.mn



+976 7777 0508



www.redcross.mn



SECIM

"Монгол Улсад Хөдөлмөр
эрхлэлтийг дэмжих" төсөл



БЗД, Энхтайваны өргөн чөлөө,
ЗГ-ын IX байр, 23 тоот



leather@unido.org



+976 7018-0180



<https://capacitydevelopment.unido.org/moodle/>

